

146

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

[illegible]

					заасан зөрчил гаргасан нийт 15 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд сонсох ажиллагааг явуулж, эрхийг ГЕГ-ын даргын 2024 оны А/06, А/211, А/244 А/434, А/609, А/546, А/623 тушаалаар эрхийг хүчингүй болгож, системд ажиллах эрхийг 6 сарын хугацаатай хаасан. -Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.6 дахь заалт, ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвийн давтан шалгалтын дүнг үндэслэн А/393, А/433, А/467 тоот тушаалаар 7 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг сэргээсэн.		
2	Гаалийн зуучлагч	Хэрэгж илт, гүйцэтг элээр	90	2.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулах	2. 2019 онд Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлж байсан ч тухайн үед стандартыг танайхаас боловсруулахгүй гэдэг хариуг ирүүлсэн. Харин "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, тус журмын 2 болон 3 дугаар зүйлд "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааны зохицуулалт", "Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд тавигдах шаардлага, үйл ажиллагааны зохицуулалт" гэсэн зүйлийг шинэчлэн боловсруулж тусгасан. Тус журмын төслийг 2024.12.06-ний өдрийн МЗхурлаар хэлэлцүүлэхээр бэлэн болгов.	01.01-12.10	95
3	Гаалийн зуучлагч	Хэрэгж илт, гүйцэтг элээр	90	3.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.	Гаалийн газар, хороодын дарга нарт 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02-2.1/976 тоот албан бичгээр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж, системд ажиллах эрх нээлгэсэн гаалийн бүртгэгдсэн мэргэжилнүүдийг нэрсийг хүргүүлж, дадлага, туршлага хуримтлуулах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эхний 6 сарын хугацаанд томилогдсон газар тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн тухайн гаалийн газар хорооны хяналтад байгаа барааг мэдүүлэхэд анхаарч, хяналт тавьж ажиллахыг мэдэгдэж, CERP програмд үүрэг даалгавраар өгч, биелэлтийг гаргуулсан. -Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02-2.1/250 дугаартай албан бичгээр гаалийн газар, хороодод үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн 2023 оны сүүлийн хагас жилийн үнэлгээг тусгай зөвшөөрлийн цахим системд дүгнүүлэх болсон тухай, хэрхэн нэвтэрч, өөрийгөө үнэлэх талаар заавар зөвлөгөөг өгсөн мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн ГБМ эрх авсан ажилтнуудыг дадлага, туршлага хуримтлуулах эхний 6 сарын хугацаанд томилогдсон газар тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн тухайн гаалийн газар хорооны хяналтад байгаа барааг мэдүүлэхийг зуучлагч байгууллагад мэдэгдэж ажиллахыг 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 02-2.1/975 тоот албан бичгээр хүргүүлсэн. -ГБМ-ийн "Өөрийн үнэлгээний хуудас"-ыг тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрүүлж, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн 2023 оны сүүлийн хагас жилд хийсэн ажлыг "Өөрийн үнэлгээний хуудас"-аар баталгаажуулж дүгнэлээ. 2023 оны сүүлийн хагас жилд идэвхтэй ажилласан /эрх хүчингүй болсон, жирэмсний амралт болон бусад шалтгаанаар ажлаас түр чөлөөлөгдсөн, гарсанаас бусад/ нийт 270 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнийг дүгнэж, нэгтгэл дүнг гаалийн газар, хороодоос албан бичгээр авч ажилласан. -Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний "Өөрийн үнэлгээний хуудас"-ыг тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрүүлж, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн 2024 оны эхний хагас жилд хийсэн ажлыг "Өөрийн үнэлгээний хуудас"-аар баталгаажуулж дүгнэлээ. 2024 оны эхний хагас жилд идэвхтэй ажилласан /эрх хүчингүй болсон, жирэмсний амралт болон бусад шалтгаанаар ажлаас түр чөлөөлөгдсөн, гарсанаас бусад/ нийт 345 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнийг дүгнэж, нэгтгэл дүнг гаалийн газар, хороодоос албан бичгээр авч ажилласан.	01.01-12.10	90

-ГЕГ-ын дэд даргын "Улсын төсвийн орлогын 2024 оны төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх шуурхай ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Барааг үнэн зөв мэдүүлэхтэй холбоотой олон талт арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд гаалийн газар, хороодод энэ чиглэлээр ажил зохион байгуулах талаар 02-2.1/2470 дугаартай албан бичгээр хүргүүлж, хийсэн ажлын тайланг 2024.08.15-ны дотор хүлээн авч, нэгтгэж удирдлагад танилцуулсан.

-Гаалийн газар, хороодын дарга нарт гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн цахим гарын үсэг ашиглалтын судалгааг гаргаж ирүүлэх тухай 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 02-2.1/2985 тоот албан бичгээр хүргүүлж, судалгаанд дүн шинжилгээ хийж ажилласан. Судалгаанд нийт 338 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн хамрагдсанаас 254 нь буюу 75.1% нь цахим гарын үсэг авсан ч ашиглахгүй байгаа, 24.8% нь огт аваагүй нь тогтоогдсон.

-<http://portal.ecustoms.mn>, <https://cims.gaali.mn>-д гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний бүртгэлийн системийг нэгтгэх, нэвтрэлтийг зөвхөн нэг системд шилжүүлэх, цахим гарын үсгийн ашиглалтыг нэмэгдүүлэх талаар Мэдээллийн технологийн төвд 02-2.1/0167 дугаартай дотоод зурвасыг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлсэн. Үүний дүнд системд ID код, мэйл хаягаар нэвтрэн орохыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зогсоож, цахим гарын үсгээр нэвтрүүлэхээр болж, хэрэгжилтийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг гаалийн зуучлагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд хүргэж ажиллахыг 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 02-2.1/3803 дугаартай албан бичгээр Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд хүргүүлсэн. Мөн гаалийн газар, хороодын дарга нарт гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн цахим гарын үсгээр нэвтрүүлэх бэлтгэл ажлын хэрэгжилтийг ханган ажиллах талаар 02-2.1/4072 тоот албан бичгээр хүргүүлж ажилласны дүнд 2024 оны 11 сарын 05-ны өдрөөс эхлэн cims.gaali.mn-д тоон гарын үсгээр нэвтрүүлэх ажлыг амжилттай нэвтрүүлсэн.

-Гаалийн цахим үйлчилгээний систем <https://gaali.mn/>-ийн "Лавлах сан" дахь зуучлагч байгууллагын жагсаалтыг шинэчлэх зорилгоор Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 75 аж ахуйн нэгжийн жагсаалтыг Мэдээллийн технологийн газарт 02-2.1/181 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.

-Иргэн, аж ахуйн нэгжид тэгш, хүртээмжтэй, хурдан шуурхай хуулийн хүрээнд үйлчлэх, ГБМ-ийн ёс зүй, үйлчилгээний чанарыг сайжруулах, тусгай зөвшөөрөл болон гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг ханган ажиллах, иргэн, хуулийн этгээдээ олгож байгаа итгэмжлэлийн шаардлагыг хангаж ажиллах талаар Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 02.21/4884 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг ирүүлэх 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг мэдэгдсэн.

-ГЕГ-ын дэд даргын баталсан Замын-Үүд дэх гаалийн газарт албан томилолтоор ажиллах ажлын удирдамжийн дагуу ЗҮГГ-т 2024.06.19-24-ний хугацаанд ажиллаж, журмын хэрэгжилтийн байдал, барааг үнэн зөв мэдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцаж, зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан.

- Гаалийн зуучлагч байгууллага, шинээр зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл хүсч байгаа аж ахуйн нэгж, бусад гадаад худалдаа эрхлэгч өөрөө мэдүүлэгч байгууллагаас анхан шатны сургалтад 63 ААН-ээс 131 ажилтныг хамруулахаар хүсэлт ирүүлснийг судлан ЗУГ-ын дарга Б.Хосбаярт танилцуулсан. Сургалтын төвөөс 2024 онд зохион байгуулсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад 102 хүн хамруулж, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/126 дугаар тушаалаар гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг 2 жилийн хугацаатай олгосон. Сургалцагчдын 75 нь гаалийн зуучлагч байгууллагын ажилтан, 18 нь гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэхэд 2 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй байх

4	Гаалийн зуучлагч	Хэрэгж илт, гүйцэтг элээр	90	4.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний алдаа суурь түвшингээс 5-аас дээш хувиар буурсан байна.	Алдаатай мэдүүлгийн тайланг гаргаж, нийт бичлэгийн 5 хувиас дээш алдаа гаргасан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн судалгааг гаргаж, гаалийн газар, хороодод журмын 7 зүйлийн 7.3 дахь заалт буюу гаалийн газар, хороодын саналаар түдгэлзүүлэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хороодын тайлан хариуцсан ГУАБ, ГУБ нарт тухай бүр мэдэгдэж ажилласан. -2023 оны эхний 11 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2414140 бичлэг бүхий бараанд экспортын 564101, импортын 345141, нийт 909242 гаалийн мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн. 2024 оны эхний 11 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 2846240 бичлэг бүхий бараанд экспортын 707718, импортын 399509 нийт 1107227 гаалийн мэдүүлэг бичигдсэн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бичлэгийн тоо 432100 буюу 15,1%, экспортын 143617 буюу 20.3%, 54368 буюу 13,6%, нийт гаалийн мэдүүлгийн тоо 197985 буюу 17,8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Барааны бичлэг болон гаалийн мэдүүлгийн тоонд цахим /өөрөө/-аар болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээр мэдүүлснийг дараах байдлаар харуулвал: <table><tr><th rowspan="3"></th><th colspan="4">2023 оны 11.30-ны байдлаар</th><th colspan="4">2024 оны 11.30-ны байдлаар</th></tr><tr><th colspan="2">Цахим/өөрөө/</th><th colspan="2">ГБМ</th><th colspan="2">Цахим/өөрөө/</th><th colspan="2">ГБМ</th></tr><tr><th>тоо</th><th>хувь</th><th>тоо</th><th>хувь</th><th>тоо</th><th>хувь</th><th>тоо</th><th>хувь</th></tr><tr><td>Бич</td><td>791910</td><td>32,8 %</td><td>1622230</td><td>67,2 %</td><td>913645</td><td>32,1%</td><td>1929952</td><td>67,9 %</td></tr><tr><td>Мэд</td><td>541630</td><td>59,6 %</td><td>367603</td><td>40,4 %</td><td>595313</td><td>53,8%</td><td>511914</td><td>46,2 %</td></tr></table> 2023 оны мөн үеийн байдлаар 2414140 бичлэг бүхий бараанд нийт 909233 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 63207 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүнээс гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр 8023 гаалийн мэдүүлэг буцаагдаж, нийт алдаатай мэдүүлгийн тоо 55184 байна. Нийт алдаатай мэдүүлгийн тоог нийт барааны бичлэгийн тоонд харьцуулахад 2.3%, нийт мэдүүлгийн 6,1%-ийг эзэлж байна. Алдаатай мэдүүлгийн 5421 нь өөрөө барааг гаальд мэдүүлэх, 49763 нь ГБМ-ээр дамжуулан мэдүүлсэн. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 2,06 хувь, өөрөө мэдүүлсэн алдааг нийт бичлэгт харьцуулахад 0,22 хувийг эзэлж байна. 2024 оны тайлант үеийн байдлаар 2846240 бичлэг бүхий бараанд нийт 1107227 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 88699 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүнээс гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр лабораторийн дүгнэлт, экспертизийн акт оруулах, зөрчлийн улмаас засварт буцаасан гаалийн мэдүүлгийн тоо 15974 байна. Алдаатай гаалийн мэдүүлгийн тоо 72022 байгаа бөгөөд нийт алдаатай мэдүүлгийн тоог нийт барааны бичлэгийн тоонд харьцуулахад 2,5%, нийт мэдүүлгийн 6,5%-ийг эзэлж байна. Алдаатай мэдүүлгийн нь 1403 өөрөө гаальд мэдүүлэх, 70619 нь ГБМ-ээр дамжуулан мэдүүлсэн. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 2,4%, өөрөө мэдүүлсэн алдааг нийт бичлэгт харьцуулахад 0,5%-ийг эзэлж байна. Ийнхүү нийт алдаатай мэдүүлгийн тоо 2023 оны тайлант үеэс 23,3 %-иар өссөн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад барааны бичлэг 15,1%, мэдүүлгийн тоо 20,3%-иар өссөн нь нөлөөлсөн байна. ГБМ-ийн мэдүүлгийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулсан мөн үеийн дүнгээс 0,4%-аар өссөн, цахимаар өөрөө гаальд мэдүүлэгчийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулсан мөн үеийн дүнгээс 2,1%-иар буурсан дүнтэй байна.		2023 оны 11.30-ны байдлаар				2024 оны 11.30-ны байдлаар				Цахим/өөрөө/		ГБМ		Цахим/өөрөө/		ГБМ		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	Бич	791910	32,8 %	1622230	67,2 %	913645	32,1%	1929952	67,9 %	Мэд	541630	59,6 %	367603	40,4 %	595313	53,8%	511914	46,2 %	01.01-12.10	90
	2023 оны 11.30-ны байдлаар				2024 оны 11.30-ны байдлаар																																													
	Цахим/өөрөө/		ГБМ		Цахим/өөрөө/		ГБМ																																											
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь																																										
Бич	791910	32,8 %	1622230	67,2 %	913645	32,1%	1929952	67,9 %																																										
Мэд	541630	59,6 %	367603	40,4 %	595313	53,8%	511914	46,2 %																																										

Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх

1	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгж илт, гүйцэтг элээр	90	Үнийн мэдээллийн санг 250,000-аас доошгүй мэдээллээр баяжуулах, хэлцлийн бус аргаар үнэлсэн нийт бичлэгийн 25-аас доошгүй хувийг үнийн мэдээллийн сангийн мэдүүлэгтэй харьцуулан үнэлсэн байна.	Импортын барааны бичлэгийн өмнөх оны мөн үеэс 15.2%-иар өссөн боловч үнэлгээ хариуцсан ГУБ-ын орон тоо хасагдаж нэг ГУБ-д ногдох бичлэгийн тоо 72.8%-иар өссөн, мөн гаалийн үнэлгээний гомдол маргаан 2023 онд 54 гарч байсан бол 2024 оны хагас жилд 57 гарсан, мөн бусад барааны үнийн судалгаа хийх, гаалийн үнийг цахимжуулах ажлыг эхлүүлэх зэрэг ажлуудыг хийх зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг хийсэн. Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан 1 ГУБ-ын ачаалал нэмэгдэж 2024 оны эхний хагас жилийн байдлаар Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажил 43.6%-тай байна. Иймд танилцуулга мэдээллийг бэлтгэн, Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх, цахимжуулах боломжийг судлах ажлын хэсэг байгуулах саналыг ГЕГ-ын удирдлагад танилцуулж, ГЕГ-ын даргын 2024.07.02-ны Б/513 дугаартай тушаалаар 3 албан хаагчийг тус нэгжид түр тушаалаар ажиллуулсан. Үнийн мэдээллийн санг 258,120 барааны үнийн мэдээллээр баяжуулан гаалийн үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Хэлцлийн бус аргаар үнэлсэн нийт бичлэгийн 37.4%-ийг үнийн мэдээллийн сангийн мэдүүлэгтэй харьцуулан гаалийн үнийг хянасан байна. Үр дүн: 1. Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, цахимжуулах боломжийг судлах зорилгоор 3 албан хаагчийн тус нэгжид түр хугацаагаар ажиллуулснаар 2024 оны эхний хагас жилд Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажил 43.6%-тай байсан бол 258,120 бичлэг буюу 103%-тай биелсэн. 2. 2024.11.30-ны өдрийн байдлаар хэлцлийн бус аргаар гаалийн үнийг тодорхойлсон нийт 547,428 бичлэгийн 37.4%-ийг "Үнийн мэдээллийн сан"-гийн "Баталгаажсан үнийн мэдээлэл"-тэй харьцуулан гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж ногдуулсан татварын зөрүү 106.8 тэрбум төгрөг байна. 3. Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг цахимжуулах програмын шийдлийг гаргаж, "Гаалийн үнийн мэдээллийн санг автоматаар бүрдүүлэх түр заавар"-ын төслийг боловсруулсан. Зарим нэр төрлийн автомашины гаалийн үнийг системээс автоматаар шалгах програмыг нэвтрүүлсэнтэй холбоотой системээс автоматаар үнэлсэн мэдүүлгийг Баталгаажсан үнийн санд автоматаар оруулах боломжтой гэж үзэн МТГ-т 02-2.1/226 дотоод зурвасаар санал хүргүүлж, програмд холбогдох өөрчлөлтийг оруулах ажил хийгдэж байна.	01.01-12.10	88
2	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгж илт, гүйцэтг элээр	90	Хил орчмын болон тээврийн хэрэгслийн үнийн судалгааг тухай бүр хянаж, хариуг хүргүүлэх, үнийн хяналтын зорилгоор	1. ГГТТХ-ийн 15.2.2.5-д заасны дагуу ГГХ-той хамтран "Хил орчмын үнийн судалгаа" хийн, хянаж, баталгаажуулан гаалийн үнийг хяналтын зорилгоор ашиглаж байна. Үүнд: - Замын-Үүд дэх гаалийн газарт улирлын чанартай үнэ хэлбэлздэг барилгын материалын хил орчмын судалгаа хийж ирүүлэх талаар 2024.01.16-ны 02.2.1/213 тоот албан бичгээр чиглэл хүргүүлж, 98 нэр төрлийн барилгын барааны үнийн судалгааг хийж ирүүлснийг хянаж, 2024.03.27-ны 02-2.1/1173 тоот албан бичгээр чиглэл хүргүүлэн CAIS-ийн "Хил орчмын үнийн судалгаа хэсэг"-т судалгааны <u>0320240200001</u> дугаартай хавтсанд байршуулан 2024.04.04-ний өдөр баталгаажуулсан.	01.01-12.10	88

			ашигласан байна. - Тус нэгжээс улирлын чанартай үнэ хэлбэлздэг бараа, гаалийн үнэлгээний гомдол их гардаг барааны БНХАУ-ын зах зээлийн үнийн судалгаа хийх зорилгоор ГЕГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, удирдамж батлуулан 2024.05.12-17-ны өдрүүдэд БЦТ, ЗУГГ-ын Гаалийн бүрдүүлэлтийн албаны албан хаагч нар болон [REDACTED]-ийн төлөөллийн хамт [REDACTED] төмөр, төмөр хийц, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, ачааны автомашины үнийн судалгаа хийсэн. Ажлын хэсэг 206 нэр төрлийн барааны үнийн судалгааг нэгтгэн хянаж, 88 барааны үнийг хил орчмын үнийн судалгаа хавтсанд байршуулах чиглэлийг ЗУГГ-т 2024.05.28-ны 02-2.1/2068 тоот албан бичгээр хүргүүлж, үнийн судалгааны 0320240300002 дугаартай хавтсанд байршуулан, 2024.06.04-ний өдрөөс эхлэн үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна. - ДоГГ-аас 73 нэр төрлийн барааны үнийн судалгааг хийж ирүүлснийг хянаж, 2024.04.24-ний 02-2.1/1613 тоот албан бичгээр, БӨГГ-аас 87 нэр төрлийн барааны үнийн судалгааг хийж ирүүлснийг хянаж, 2024.04.24-ний 02-2.1/1614 тоот албан бичгээр чиглэл тус тус хүргүүлсэн. Дээрх хил орчиын судалгааны үнэтэй харьцуулан 255,775 барааны гаалийн үнийг хэлцлийн бус аргаар тодорхойлж, нэмж ногдуулсан татварын зөрүү 54.6 тэрбум төгрөг, 2. ГТГТХ-ийн 15.2.2.4-д заасны дагуу тээврийн хэрэгслийн болон вагоны үнийн судалгааг хийх чиглэлийг Бүрдүүлэлтийн цахим төвд хүргүүлж, дараах ирүүлсэн судалгааг хянаж, CAIS-ийн Үнийн судалгаа хэсэгт оруулан, баталгаажуулан үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Үүнд: - БТКУС-ийн зүйл 87.03-д хамаарах АНУ-аас импортолж байгаа суудлын автомашины үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэтэй харьцуулан хянаж, 62 барааны үнийг CAIS-ийн автомашины үнийн судалгааны 01202401000002 дугаартай хавтсанд байршуулснаар уг судалгаагаар нийт 119 автомашины гаалийн үнийг тодорхойлж, 582.3 сая төгрөг, - БТКУС-ийн Зүйл 87.04, 87.16-д хамаарах БНХАУ-аас импортлож байгаа чирэгч автомашин, чиргүүлийн үнийн судалгааг CAIS-ийн бүрдүүлэлтийн мэдээ, 2023 оны судалгааны үнэ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан нийт 5 маркын 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 154 нэр төрлийн чирэгч автомашин, 7 төрлийн 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 63 ширхэг чиргүүлийн үнийг хянаж 01202401000003 дугаартай хавтсанд байршуулсан. Уг судалгаагаар нийт 3824 чирэгч, чиргүүлийн гаалийн үнийг тодорхойлж, нэмж төлүүлсэн татварын зөрүү 22.2 тэрбум төгрөг, - БТКУС-ийн зүйл 8606-д хамаарах ОХУ-аас импортолж байгаа зарим ачааны вагоны үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан 28ш ачааны вагоны үнийг хянаж 2024.05.08-ны 02-2.1/097 тоот дотоод зурвасаар чиглэл хүргүүлэн, 01202402000001 хавтсанд тус тус оруулан баталгаажуулсан. Уг судалгаагаар нийт 82 вагоны гаалийн үнийг тодорхойлж, нэмж тодорхойлсон татварын зөрүү 774.7 сая төгрөг, 3. БНСУ-аас импортолж буй ачааны машины үнийн судалгаагаар 8342 тээврийн хэрэгслийн гаалийн үнийг тодорхойлж, нэмж ногдуулсан татварын зөрүү 6.3 тэрбум төгрөг Үр дүн:		
--	--	--	--	--	--

					- Хил орчмын үнийн судалгааг 2 удаа шинэчлэн хийж гаалийн үнийн хяналтын зорилгоор ашигласан. - БНСУ, АНУ, БНХАУ-аас импортолж байгаа суудлын болон ачааны машин, чирэгч, чиргүүлийн үнийн судалгааг тухай бүр шинэчлэн үнийн хяналтын зорилгоор ашигладаг байсан бол энэ онд ОХУ-аас импортолж байгаа вагоны үнийн судалгааг шинээр хийн, үнийн судалгааний хавтсанд байршуулан гаалийн үнийн хяналтын зорилгоор ашигласан. - Дээрх үнийн судалгаануудын үнээр нийт 267,142 барааны гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 84.5 тэрбум төгрөг байна.		
3	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90	Олон улсын тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас тээврийн зардлын тарифыг тогтмол авах ажлыг зохион байгуулах, тээврийн зардлын төрөлжсөн судалгаа хийж, гаалийн үнийн хяналтын зорилгоор ашигласан байна.	2024 оны эхний хагас жилд УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ, ЗҮГГ, ГСГГ-уудад чиглэл хүргүүлж, ачаа тээврийн үйлчилгээ хийдэг аж ахуйн нэгжүүдийн тээврийн зардлын тарифын мэдээллийг авч нэгтгэн, төмөр замын тээврийн тарифыг авах хүсэлтийг УБТЗ ХНН-д 2024.03.21-ний 02/1076 тоот албан бичгээр олон улсын тээврийн үйлчилгээний тарифийн мэдээлэл авахаар хандсан. УБТЗ ХНН-аас 2024.03.28-ны өдрийн 11/1000 тоот албан бичгээр МУ-ын хил хүртэлх тээврийн тарифыг тухайн улсын төмөр замын байгууллагаас тогтоодог тул бусад улсын тээврийн тарифын талаарх албан ёсны мэдээллийг өгөх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. Иймд ГЕГ-ын удирдлагын бүрэлдэхүүн Монголын тээвэр зуучдын нэгдсэн холбоотой 3 удаа уулзалт зохион байгуулсан бөгөөд анхны уулзалтыг 2024.07.08-ны өдөр хийж, ГЕГ-ын дэд дарга ахалж оролцсон. Уг уулзалтын дүнд ГЕГ-ын дэд даргын 2024.07.23-ны өдрийн 02/2973 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр 2024 оны 08-р сарын 01-ний өдрөөс эхлэн гадаад тээврийн зардал төлсөн тухай цахим төлбөрийн баримтын систем-ebaimt.mn-ээс хэвлэгдсэн төлбөрийн баримтыг үндэслэж гаалийн бүрдүүлэлт хийх тухай чиглэл өгч, импортлогч аж ахуйн нэгж болон иргэдийн ebaimt.mn системээс гаргаж өгсөн гадаад тээврийн зардлын баримтыг үндэслэн бичиг баримтын шалгалтыг хийж байна. Гадаад худалдаа эрхлэгч нарын гаргаж өгч байгаа гадаад тээврийн зардлын баримт нь дараах 3 загвартай байна. Үүнд: - Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал “Маягт, заавар батлах тухай” тушаалаар батлагдсан загвартай “Төлбөрийн баримт” гарчигтай баримт - Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал “Маягт, заавар батлах тухай” тушаалаар батлагдсан загвартай “Нэхэмжлэх” гарчигтай баримт - ТЕГ-ын даргын 2020 оны А/02 дугаар тушаал “Падаан, баримт, гэрчилгээний загвар, албан татвар суутган төлөгч болон албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах журам батлах тухай” тушаалаар батлагдсан загвартай “Төлбөрийн баримт” гарчигтай баримт Гадаад тээврийн зардлын и-баримт хавсаргахгүй хийгдэж байгаа бүрдүүлэлтүүд: - БНХАУ-ын Эрээн хотоос машинаар тээвэрлэгдэж ирж байгаа ачаанууд - Гадаад тээвэр зуучтай ачаанууд	01.01-12.10	85

4	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгж илт, гүйцэтг элээр	100	Гаалийн улсын байцаагч нар болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүд эд үнэ, үнэлгээтэй холбоотой удирдамж, чиглэлээр хангах, зөвлөгөө өгөх, асуудал хариуцсан ажилтнуудыг сургалтад хамруулах, чадавхижуулах ажлыг зохион байгуулсан байна.	- 2024 оны эхний 5 сарын бүрдүүлэлтийн гаалийн үнэлгээнд дүн шинжилгээ, үнийн судалгаа хийж, гарч байгаа алдаа, гаалийн үнэлгээнд анхаарах асуудлаар 2024.05.02-ны өдөр Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч нарт анхааруулга, чиглэл, мэдээлэл өгсөн. - Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний 1 удаагийн анхан, 3 удаагийн давтан сургалтанд гаалийн үнэ, үнэлгээний чиглэлээр нийт 4 удаа сургалт хийсэн. - Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагчдад зориулсан “Гаалийн үнэлгээний ахисан түвшний сургалт”-ын хөтөлбөрийг 2024.10.23-ны өдөр ГЕГ-ын даргаар батлуулан, холбогдох бэлтгэл ажлыг ханган, 2024 оны 11 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар ДХБ-ын гаалийн үнэлгээний хэлэлцээрийн хэрэгжилт, Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалтыг биелүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн бүх үе шатанд гаалийн үнэлгээний хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлуудыг багтаасан. Гаалийн байгууллагад мэдүүлж буй барааны ангилал, гаалийн үнэлгээний луйвар, мөнгө угаахтай холбогдох эрсдлийг таньж илрүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд гардаг алдаа, гомдол, маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудлуудыг практик дээр гардаг алдаа дутагдалтай холбон ярьсан нь үр дүнтэй байсан. Түүнчлэн төрийн албан хаагчийн ёс зүй, авлигаас урьдчилан сэргийлэх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шинжээчээр ажиллах эрх зүйн үндэслэл, шинжээчийн үүрэг, дүгнэлт гаргах үйл ажиллагааны талаар онцгойлон анхаарч, Удирдлагын академи, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Криминалистикийн хэлтэс, Авлигатай тэмцэх газраас холбогдох мэргэжилтнүүдийг сургалтад урьж оролцуулсан нь сургалтын үр дүнг нэмэгдүүлж, хууль эрх зүйн орчинд шинэлэг өөрчлөлт хийх суурь болж байна. Мөн сургалтын сүүлийн өдөр Урлагийн сэтгэл засал судлалын үндэсний төвөөс Стресс менежмент сэдвээр сургалтыг оруулснаар оролцогчид ажлын ачааллын үед стрессээ тайлах аргын талаар сурсан цаг үеэ олсон үр дүнтэй байна гэсэн үнэлэлт авсан. Сургалтын төгсөлд сургалтад хамрагдагчдаас сургалтын үнэлгээний хуудас авсан бөгөөд 81.3% нь сургалтын агуулгыг бүхэлдээ ач холбогдолтой байсан гэж хариулсан байна. Сургалтын дэлгэрэнгүй тайланг Сургалтын төвд хүргүүлсэн. Чиглэл: - Татвар орлогын газраас татварын орлогын төлөвлөгөөний асуудлаар 2024.05.08-ны өдөр ГГХ-дтой хийсэн цахим хуралд гаалийн бүрдүүлэлт, гаалийн үнэлгээнд анхаарах барааны жагсаалтыг ГГХ бүрээр гаргаж танилцуулсан. - ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2024.06.03-ны өдөр БЦТ-ийнхэнтэй хийсэн уулзалтад гомдол маргаан шийдвэрлэлт, гаалийн үнийн хяналтыг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, засвар буцаалтад анхаарах анхааруулга чиглэл хүргүүлсэн. - Замын-Үүд дэх гаалийн газрын Гаалийн бүрдүүлэлтийн албаны дарга, ГУБ нартай 2024.05.17-ны өдөр уулзалт хийж, гарч байгаа хүндрэлийн талаар ярилцаж, холбогдох чиглэлийг өгсөн. - “Гааль зөвшөөрөв” төлөвт орсон мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, нэмэгдэх болон тээврийн зардал дутуу тооцсон 21, харьцуулах баримт буруу сонгож үнэлсэн 21 мэдүүлгийн гаалийн үнийг дахин хянах, үнэлгээний арга буруу сонгосон 1 мэдүүлгийн алдааг засах чиглэлийг Бүрдүүлэлтийн цахим төвд дотоод зурвасаар өгсөн. Чиглэлийн дагуу одоогоор 6 мэдүүлгийн алдааг засч, 2 мэдүүлгийг засварт буцаах арга хэмжээг авсан байна.	01.01-12.10	95
---	----------------------	---------------------------	-----	---	---	-------------	----

				- Бүрдүүлэлтийн цахим төвд гаалийн үнэлгээтэй холбоотой гарч буй алдаа болон анхаарах чиглэлийг 7 удаа дотоод зурвасаар чиглэл, зөвлөмж хүргүүлсэн. Үр дүн: 1. Сургалтаар гаалийн үнийг хэлцлийн бус аргаар тодорхойлоход харьцуулах баримтыг зөв сонгох, гомдол маргаан шийдвэрлэхдээ шийдвэрийн үндэслэлийг тодорхой бичиг зэрэг анхааруулгыг өгсний дүнд сургалтаас хойш гаалийн үнэлгээний гомдлын тоо буурсан. Мөн сургалтын дүнд байцаагч нар Хэлцлийн үнийн санд мэдээлэл оруулах, гомдол, маргааны шийдвэрийг CAIS-ийн шийдвэрийн санд тухай бүр оруулах зэрэг ахиц гарсан байна.		
5	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлэх 1. CAIS системийн "Эрсдэлийн удирдлагын програм"-д "гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим"-той /горимын код 100/, БТКУС-ийн Зүйл 2701, 2702 кодоод хамаарах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, 2601 кодоод хамаарах төмрийн хүдэр, төмрийн баяжмалын гаалийн бүрдүүлэлтэд "биржийн гэрээ"-тэй гэж мэдүүлсэн тохиолдолд гаалийн хяналтын ногоон төлөвт оруулах саналыг 2024.05.29-ний 02-2.1/104 дотоод зурвасаар ЭУХ-т санал хүргүүлсэн боловч ЭУ-ын програмын шалгуурт дээрх шалгуур байхгүй тул боломжгүй, ААН-ийн нэр эсхүл барааны кодоор л шалгуур оруулах боломжтой гэсэн хариу өгсөн. Иймд МТГ-т 02-2.1/105 дотоод зурвасаар барааг биржтэй эсэх гэж мэдүүлсэн бол програмаас хэлцлийн үнийн аргаар ББ ГУБ томилохгүйгээр автоматаар үнэлэх саналыг өгч уулзалт хийсэн. 2. Гаалийн үнийн судалгаа болон холбогдох гомдол мэдээллийн дагуу Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт 3 удаа дотоод зурвасаар нийт 27 ААН-ийг шалгуулах санал хүргүүлсэн. Үүнд: 2024.01.25-ны 02-2.1/18 дугаартай дотоод зурвасаар Холлмарк ХХК, 2024.02.20-ны 02-2.1/31 дугаартай дотоод зурвасаар 25 ААН, 2024.06.12-ны 02-2.1/115 дотоод зурвасаар Номин Интер трейд ХХК. Тус нэгжээс 2023 оны 11 сард БДШ оруулах санал өгсөн ААН-үүдээс 3 ААН-д шалгалт оруулсны 1 ААН-д шалгалтаар зөрчил илрээгүй, 2 ААН-д 92.4 сая төгрөгийн нөхөн татвар болон торгууль ногдуулсан байна. 3. ГГХ, БЦТ болон БАҮХ-ийн ажлын уялдаа холбоог сайжруулах, үнийн гомдол их гарч буй барааны БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат, Эрээн хотуудын зах зээлийн үнийн судалгаа хийх, бодит байдалтай танилцах зорилгоор ГЕГ-ын даргын тушаалаар 2024.05.12-оос 17-ны өдрүүдэд анх удаа хамтарсан үнийн судалгааг хийсэн. Уг судалгааны ажлын явцад гаалийн үнийн хяналт тавих, мэдээлэл солилцох дараах боломжийг бүрдүүлсэн. - БНХАУ-ын төмрийн үнийн мэдээллийг цахимаар шалгах сайттай холбогдож, уг сайтад хандах эрхийн үнийн саналыг авч, санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлхээр СХОГ-т 2024.06.07-ны 02-2.1/110 дотоод зурвасаар хүргүүлж, шийдвэрлүүлсэн. [redacted] хотын [redacted] компанийн төмрийн нээлттэй биржийн цахим хуудас www.lgmi.com-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг 2024.06.21-ний өдөр авч, сайтад хандах эрхийг мэдээллийг Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.06.24-ний өдрийн 02-2.1/115 дотоод зурвасаар хүргүүлж, үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Тус сайтаас төмрийн өдөр бүрийн үнийн мэдээллийг хотуудаар болон 6 сараар харах, мөн тээврийн зардлыг харах боломжтой юм. Цаашид сайтад хандах эрхийн санхүүгийн асуудлыг жил бүрийн гаалийн байгууллагын төсөвт оруулан батлуулах ажлыг хэвшүүлснээр гаалийн үнэлгээний гомдлын ихэнхи	01.01-12.10	95

				хувийг эзэлдэг төмрийн өдөр тутмын үнийн мэдээллийг харах боломжтой болж, үнийн хяналт сайжирна гэж үзэж байна. төмрийн үйлдвэр болон хүнд машин механизмын үйлдвэр, ийн борлуулалтын үнийн мэдээллийг авч, цаашид үнийн хяналтын зорилгоор тухай бүр үнийн мэдээлэл авах холбоо барих боломжийг бүрдүүлсэн. - БНХАУ-д үйлдвэрлэгдсэн суудлын автомашины арлын дугаараар хайлт хийхэд техникийн үзүүлэлт болон үнийн мэдээлэл гардаг сайтын хаягийг авч, хяналтын зорилгоор ашиглах боломжтой болсон. 4. Япон улсад экспортын гаалийн бүрдүүлэлт хийгдсэн хуучин автомашины марк, арлын дугаар болон гаалийн үнийн мэдээллийг цахимаар ирүүлэх боломжтой эсэх, мөн биржээр арилжаалагдаж байгаа автомашины үнийн болон холбоотой мэдээллийг хэрхэн авах талаар зөвлөгөө авах хүсэлтийг Гадаад хамтын ажиллагааны хэлтсээр дамжуулан Японы гаалийн байгууллагад цахимаар хүргүүлсэн. Японы гаалийн байгууллагаас цахимаар хариу ирүүлэхдээ гаалийн үнийн мэдээллийг ирүүлэх боломжгүй талаар дурдаж, статистик мэдээллийн вэбсайтын хаягыг ирүүлсэн. 5. Япон улсад дуудлага худалдаагаар арилжаалсан хуучин тээврийн хэрэгслийн мэдээллийг харах боломжтой сайтуудын талаар холбогдох мэдээллийг судалсны үндсэн дээр ОХУ-ын цахим хаягын Монгол дахь төлөөлөгч 2024.11.06-нд албан бичгээр хандсаны дагуу ийн гүйцэтгэх захирал Бороков И.В-аас 20241115/11 албан бичгээр хариу мэдээлэл ирүүлсэн. Тус хариу албан бичгийг хүлээн авч тус компанийн төлөөлөгч 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Гаалийн ерөнхий газрын ТОГ-ын дарга С.Баярмаа, БАҮХ-ийн дарга үнэлгээний чиглэл хариуцсан байцаагч нарын бүрэлдэхүүнтэйгээр албан уулзалтыг хийсэн. Уулзалтаар тухайн сайтын талаар тодорхой мэдээлэл авсан бөгөөд бусад орнуудтай хэрхэн хамтарч ажилладаг талаарболон сайтын эрхийн үнийн саналыг албажуулан ирүүлэхээр болсон. Үр дүн: 1. Тус нэгжээс хийсэн төрөлжсөн үнийн судалгааны явцад эрсдэл тооцон шалгуулхаар БДШГ-т өгсөн ААН-үүдээс 3 ААН-д шалгалт оруулсны 1 ААН-д шалгалтаар зөрчил илрээгүй, 2 ААН-д 92.4 сая төгрөгийн нөхөн татвар болон торгууль ногдуулсан байна. 2. Тус нэгжээс ГГХ, ГЕГ-ын ажлын уялдаа холбоог сайжруулах, үнийн гомдол их гарч буй барааны зах зээлийн үнийн судалгаа хийх зорилгоор ГЕГ-ын даргын тушаалаар анх удаа хамтарсан үнийн судалгааг хийх ажлыг амжилттай зохион байгуулсан. Судалгааны гол үр дүнд төмрийн нээлттэй биржийн цахим хуудас хандах 1 жилийн албан ёсны эрхийг авч, үнийн хяналтын зорилгоор ашигласнаар төмрийн гаалийн үнэлгээний гомдлын тоо буурсан.		
6	Гаалийн үнэ, үнэлгээ	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. Экспортын биржээр арилжаалагдаж байгаа эрдэс баялагын бүтээгдэхүүний судалгааг хийж, CAIS системд "гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим"-той /горимын код 100/, БТКУС-ийн Зүйл 2701, 2702 кодоод хамаарах, нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн, 2601 кодоод хамаарах төмрийн хүдэр, төмрийн баяжмалын гаалийн бүрдүүлэлтэд "биржийн гэрээ"-тэй гэж мэдүүлсэн тохиолдолд бичиг баримтын байцаагч хуваарилагдахгүй, мэдүүлэг бичиг баримтын шалгалт хийгдсэн төлөвт ордог байх прорамын саналыг МТГ-т 2024.05.29-ний 02-2.1/105 дотоод зурвасаар хүргүүлж, МТГ-ын дарга, ГУАБ-тай уулзалт хийж, програмын аргаар шийдэх боломжтой гэсэн хариуг авсан.	01.01-12.10	98

					Зарим нэр төрлийн импортын суудлын автомашинд бичиг баримтын гаалийн бүрдүүлэлт хийхэд тухайн иргэн, аж ахуйн нэгжийн хэлцлийн үнийг үндэслэн Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем /цаашид КАИС/-ээс гаалийн үнийг автоматаар хянах програмыг нэвтрүүлэх, "Автомашинны гаалийн үнийг системээс автоматаар хянах түр заавар"-ыг 2024.09.19-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн ээлжит 5 дугаар хурлаар хэлэлцүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу дараах арга хэмжээг авсан. Үүнд: - Гаалийн үнийн судалгааг Toyota, Prius автомашины сүүлийн 3 сарын хугацаанд 400 горимын, 110 хэлцлийн кодтой, дуудлага худалдааны бичиг баримттай, эвдрэлгүй байх нөхцлийг хангасан, хэлцлийн үнийн аргаар үнэлсэн гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг үндэслэн, барааны гарал үүслийн улс, илгээгч улс, үйлдвэрлэгч, марк, кузовын төрөл, хөдөлгүүрийн төрөл болон багтаамж, үйлдвэрлэсэн он, БТКУС-ийн ангиллын код гэсэн үзүүлэлтээр гаалийн үнэ, тээврийн зардал, нэмэгдэх зардлыг тооцон гаргаж, гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн "Автомашин өөрөө үнэлэх жагсаалт" цэсэнд нийт 69 үнийн мэдээллийг оруулж, баталгаажуулсан. - "Автомашинны гаалийн үнийг системээс автоматаар хянах түр заавар"-ыг ГЕГ-ын даргын 2024.10.02-ны өдрийн А/533 тоот тушаалын хавсралтаар батлуулсан. - Програмыг 3 сарын хугацаатайгаар 2024.10.01-ний өдрөөс эхлэн туршилтаар нэвтрүүлсэн. Гаалийн үнийг цахимжуулах эхний алхам хийгдэж, Япон улсаас импортолж буй автомашины гаалийн үнийг автоматаар үнэлэх түр зааврыг батлуулж, програмыг туршилтын журмаар нэвтрүүлснээр дараах үр дүн гарсан. - 2024.10.01-2024.11.30-ний өдрүүдэд Япон улсаас импортолсон, улаан төлөвт сонгогдсон нийт 7507 мэдүүлгийн 48%-ийг системээс автоматаар шалгаж, бичиг баримтын шалгалт хийгдсэн. - Урьдчилан оруулсан шалгуур үзүүлэлтийг тооцож системээс автоматаар шалгасан мэдүүлэг бичиг баримтын шалгалт дууссан төлөвт орох хугацаа 0 минут болсон, - Ажлын 1 өдөрт 1 ГУБ-д 46 бүрдүүлэлт ногдож байгаа бөгөөд 1 өдөрт 150 мэдүүлгийг системээс автоматаар шалгасан нь 3 ББ ГУБ-ийн ажилтай тэнцүү буюу 3 ББ ГУБ-ийн ажлыг хэмнэсэн байна. - Мэдээ тайлан гаргах зорилгоор КАИС програмд нэмэлт цэс гаргаж, дүн шинжилгээ хийж, өдөр тутмын хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.		
7	Гаалийн үнэ, үнэлгээ, барааны ангилалтай холбоотой асуудлаар маргаан, гомдлын шийдвэрлэлт, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой ирүүлсэн санал, хүсэлт болон газар, хороодын даргын шийдвэрт гаргасан гомдол маргааныг шийдвэрлэн, шийдвэрийн цахим санг	1. Тайлант хугацаанд БАҮХ-ээс дараах албан бичгийг хүлээн авч, хугацаанд нь хянан шийдвэрлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Үүнд: Ирсэн бичгийн тоо - 535, гомдлын тоо - 105 Явсан бичгийн тоо- 160 - Импортын барааны гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой ААН, иргэдээс ирүүлсэн анхан шатны шийдвэрийг давж заалдсан 92 гомдол ирүүлсэн. Үүнд: Иргэн 21, аж ахуйн нэгж 71 давхардсан тоогоор байна. Тухайн 92 гомдлын 52 гомдлын гаалийн улсын байцаагчийн шийдвэрийг хэвээр үлдээн 40 гомдлыг дахин хянахаар шийдвэрлэсэн байна. Мөн тус хугацаанд гаалийн байгуулгын 1281 болон иргэд, олон нийттэй харилцах төвийн 1111 -д утсаар ирсэн 5 гомдлыг хуулийн хугацаанд нягтлан шалгаж хариу өгсөн болно. Гомдол, маргааны шийдвэрийг тухай бүр CAIS-ийн гаалийн үнэлгээний шийдвэрийн санд бүртгэсэн бөгөөд 690 анхан шатны болон ГЕГ-ын шийдвэр бүртгэгдсэн байна. Мөн экспортын барааны гаалийн үнэлгээний асуудлаар 2 гомдол, хүсэлтийг судлан хариуг хүргүүлэн шийдвэрлэсэн. Тус нэгжээс гаалийн үнэлгээтэй	01.01-12.10	90

тавьсан байдал			баяжуулсан байна.	холбоотой 2 гомдолд шүүхэд давж заалдсан бөгөөд 1 гомдлыг шүүхийн шатанд нэхэмжлэх гомдлоо буцаан татаж, 1 гомдол шүүхийн шатандаа байна. 2. Тайлант хугацаанд дараах 9 аж ахуйн нэгж, иргэний гаргасан гомдол, маргаан ирсний 7 шийдвэрийг хэвээр үлдээж, 1 шийдвэр шүүхийн шатанд, 1 шийдвэрийн тайлбар хүргүүлж ажиллалаа: ХХК нь БАҮХ-ийн 2023.06.23-ны өдрийн 02-2/71 тоот БДШГ-т хүргүүлсэн "дотоод зурвас"-ыг хүчингүй болгуулах гомдол гаргасныг Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "дотоод зурвас"-ыг гаалийн удирдах төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага хооронд албан ажлын зорилгоор санал, мэдээлэл солилцох, лавлагаа мэдээлэл гаргуулах, зөвлөмж, зөвлөгөө хүсэх, хүргүүлэх зэргээр хамтран ажиллахад ашигладаг, гадагш чиглээгүй, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон шийдвэр биш тул хүчингүй болгох шаардлагагүй гэсэн тайлбарыг БДШГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн. БДШГ-аас хариуг нэгтгэн 2024.02.14-ний өдрийн 02/508 тоот албан бичгээр хүргүүлсэн. Шүүх хуралд оролцох бэлтгэл ажлын хүрээнд тус компанийн 2020-2024 онуудад бүрдүүлэлт хийгдсэн зүрхний эмтэй стент, амплатцер, судас бөглөгч гэх бараануудын мэдүүлгийн мэдээллийн нэгтгэлийг хийсэн. Мөн ХХК-ийн импортолсон бараатай холбоотой БЦТ-ийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулахаар тус компани нь шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотойгоор хариу тайлбар болон БТКУС-ийн конвенци, Ерөнхий тайлбар дүрмийг хуулбарлан хүргүүлсэн. оот мэдүүлгээр мэдүүлсэн мэдүүлгээр -ыг 3үйл 90.18-д ангилан алдаатай бүрдүүлэлт хийгдсэнийг засварт буцаан кодыг засаж, "бичиг баримтын шалгалт хийгдсэн" төлөвтэй хүлээгдэж байгааг хүлээн зөвшөөрөлгүй шүүхэд хандсаны дагуу хариу тайлбарыг бэлтгэн хүргүүлсэн. Энэ 2 бараатай холбоотой ГХАХ-ээр дамжуулан ДГБ-ын Тариф, худалдааны нарийн бичгийн дарга нарын газарт амплатцер, судас бөглөгчийн талаарх мэдээллийг ангиллын зөвлөмж авах маягтын дагуу бөглөн хүргүүлсэн. ХХК-ийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан 3 гомдолтой холбоотой асуудлаар БДШГ, ХХ, ХБГ-ын шүүх хуралд хариуцагчаар оролцож байгаа ГУБ болон ГУАБ нартай шүүх хурлын явцын талаар мэдээллээ нэгтгэх, цаашид хэрхэн оролцох асуудлаар санал солилцох 2024 оны 10-р сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан уулзалтаас үүрэг өгсөний дагуу 3 захиргааны хэргийн барааны ангилалтай холбоотой асуудлын явцын талаарх танилцуулгыг бэлтгэн хамтарсан хуралд танилцуулсан. Захиргааны 3 хэргийн шүүх хуралд нийт 13 удаа оролцож тухай бүрт нь барааны ангилалтай холбоотой тайлбарыг өгсөн. Зөрчилтэй тэмцэх газраас импортолсон гэх 3 нэр төрлийн барааны ангилалтай холбоотой асуудлаар дахин гомдол гаргасны дагуу Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ, ГУАБ нарт сургалт зохион байгуулах, чиглэл хүргүүлэх зэрэг арга хэмжээг авсан талаарх хариуг 2024.03.13-ны өдрийн 02-2.1/051 тоот дотоод зурвасаар өгсөн. аас 2024 оны 02-р сарын 19-ний өдрийн тоот мэдүүлгийн 9, 10, 12, 13 дугаар бараа болох компанид		
----------------	--	--	-------------------	--	--	--

				үйлдвэрлэсэн [redacted] гэж мэдүүлсэн барааны ангиллын кодыг засах шаардлагыг хүлээн авахгүй талаар гомдол гаргасныг судалж үзэн тайлбарыг хүлээн авах боломжгүй талаар 2024.05.27-ны өдрийн 02-2.1/2053 тоот албан бичгээр хүргүүлсэн. [redacted]-ийн 2024.09.19-ний өдрийн [redacted] тоот мэдүүлгийн 1, 2 дахь [redacted], 10, 11 дэх [redacted], 12 дахь [redacted] ыг Зүйл 90.21-ийн хүний биед суулгах зориулалттай хэрэгсэл гэдэгт хамааруулан ангилсан БЦТ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 2024/490 тоот "Гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянасан тухай шийдвэр"-ийг хүлээн зөвшөөрөлгүй гомдол гаргасныг судалж үзэн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзсан талаарх хариуг 2024.10.03-ны өдрийн 02-2.1/4031 тоот албан бичгээр хүргүүлсэн. [redacted]-аас 2024.01.14-ны 24/05 тоот албан бичгээр ирүүлсэн [redacted] гэх барааны ангиллын маргааныг судлан, БЦТ-ийн шийдвэрийг хэвээр үлдээх тухай хариуг 2024.01.23-ны 02-2.1/297 тоот албан бичгээр хүргүүлэв. [redacted] ХХК-аас 2024.03.22-ны 27 тоот албан бичгээр ирүүлсэн [redacted] гэх барааны ангиллын маргааныг судлан, БЦТ-ийн шийдвэрийг хэвээр үлдээх тухай хариуг 2024.03.27-ны 02-2.1/1170 тоот албан бичгээр хүргүүлэв. [redacted] ХХК-аас 2024.05.02-ны 24/038 тоот албан бичгээр ирүүлсэн "иж бүрэн үтрэм" гэх 7 нэр төрлийн барааны ангиллын маргааныг судлан, бараа тус бүрийн ангиллын кодыг тодорхойлон, хариуг 2024.05.03-ны өдрийн 02-2.1/1777 тоот албан бичгээр хүргүүлэв. [redacted] ас 2024.07.17-ны 001 албан бичгээр ирүүлсэн [redacted] гэх барааны ангиллын маргааныг шийдвэрлэн, 2024.07.24-ний 02-2.1/2987 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. Мөн дээрх шийдвэрийг ГЕГ-н ХХ, ХБГ, БЦТ-д дотоод зурвасаар хүргүүлсэн. [redacted] ХХК-ий 2024.07.25-ны 01/304 албан бичгээр ирүүлсэн [redacted] ийн барааны ангиллын маргааныг судлан, бараа тус бүрийн ангиллын кодыг тодорхойлон, хариуг 2024.08.01-ны өдрийн 02-2.1/3083 тоот албан бичгээр хүргүүлэв. -Иргэн [redacted] 2024.10.17-ны өдөр бичгээр ирүүлсэн [redacted] тухай хүсэлтийг судлан, зохих хариуг 2024.10.25-ны 02-2.1/4374 тоот албан бичгээр хүргүүлэв. Төрийн байгууллагаас 7 хүсэлт, 2 санал авах албан тоот, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 4 хүсэлтийг судлан хариуг хүргүүлсэн. 2. Нийт 225 дотоод зурвас боловсруулан ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад хүргүүлж мэдээлэл солилцон хамтран ажилласан. ЗББНДГ-аас ирүүлсэн дотоод зурвасын хариуг хугацаанд нь хариу хүргүүлж ажилласан.			
8	Барааны ангилал	Хэрэгжилт,	95	1. Шаардлагатай тохиолдолд үндэсний код,	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хайлуур жоншны стандартыг шинэчилсэн, "Төмрийн хүдэр, баяжмал болон төмрийн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS 7017:2023" стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн С/39 дүгээр тушаалаар шинээр батлуулсантай холбоотойгоор төмрийн хүдэр,	01.01-12.10	88

		гүйцэтг э-лээр		хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна	баяжмал, бүтээгдэхүүний үндэсний кодыг шинэчлэн боловсруулах хүсэлт ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан ГТЛ-иос холбогдох үндэсний код боловсруулах саналыг авч судлан төмрийн баяжмалыг боловсруулалтын түвшингээр нь үндэсний кодын задаргаа хийх тушаалын төслийг боловсруулсан. Үндэсний код шинэчлэн боловсруулах хүрээнд стандартуудыг судалж үзэхэд "Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал MNS 6249:2011" гэсэн Монгол Улсын стандарт хүчинтэй мөрдөгдөж байсан тул дээрх 2 стандартын төмрийн хүдэр, баяжмал, төмрийн бүтээгдэхүүний тодорхойлолт, ангилал нь хоорондоо нийцэхгүй байгаагаас үндэсний код боловсруулахад хүндрэлтэй байгааг шийдвэрлэж өгөх хүсэлтийг 2024.04.12-ны өдрийн 02-2/1417 тоот албан бичгээр хүргүүлсэн, одоогоор хариу ирүүлээгүй байна.		
9	Барааны ангилал	Хэрэгж илт, гүйцэтг э-лээр	100	2.Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд санал өгч, барааны ангиллын кодыг тодорхойлсон байна.	Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын 9 төсөлд санал өгч, 368 барааны ангиллын кодыг тодорхойлж, холбогдох яам, төрийн байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Эдгээрээс 4 тогтоол батлагдаж, 5 тогтоол хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.Үүнд: -УИХ-ын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолд заасан зорилтын хүрээнд ХХААХҮЯ-аас зарим нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын татварыг 3 жилийн хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэх УИХ-ын тогтоолын төслийг ирүүлсэн. Дээрхи төслийн хавсралтад орсон "хуурай сүү, 1,5%-аас ихгүй тослогтой" болон чацаргана /хөргөсөн, хөлдөөсөн, шүүс/ гэх барааг БТКУС-ийн жагсаалтын шинэ 6 үндэсний кодод ангилах төслийг боловсруулан, санал авахаар CERP-д байршуулж, файлаар ХХААХҮЯ болон Сангийн яамны хариуцсан мэргэжилтэн нарт хүргүүлсэн. /Уг төсөл ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа/. -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас насанд хүрэгчдийн бараа бүтээгдэхүүний ангиллын код болон хилийн хяналт шалгалтад хамрагддаг эсэх талаар мэдээлэл авах хүсэлтийг ирүүлсний дагуу эмнэлгийн хэрэгслийн жагсаалт байдаггүйгээс гаалийн бүрдүүлэлт хийхэд хүндрэл гардаг талаар 2024.01.17-ны өдрийн 02-2.1/249 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. -ХХААХҮЯ-наас 2024 оны 04-р сарын 19-ний өдрийн "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" хуулийн хүрээнд ЗГ-ын тогтоолоор батлагдах мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурил нийт 16 нэр төрлийн барааны жагсаалт ирүүлсний ангиллын кодыг хянаж, хуулийн заалтад хамаарахгүй 5 барааг хасах саналыг өгсөн. Энэ тогтоолын төсөл нь ЗГ-ын 2024 оны 05-р сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан. -Монгол Улсын хилээр 2024 онд "Импортлох мал үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцан, хавсралтад заасан 14 барааны ангиллын кодыг нягталж, залруулга хийх талаар (Цэвэр үүлдрийн үржлийн үхэр -0102.21.10) саналыг 2024.01.26-ны 02/359 тоот албан бичгээр хүргүүлэв./ ЗГ-ын 2024 оны 60-р тогтоолоор батлагдсан/. - "Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" 1998 оны Улсын Их хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай төсөлд "автомашины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс" гэх саналыг 2024.04.16-ны өдрийн 02/1453 тоот албан бичгээр УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлэв. /УИХ-ын 2024 оны 35-р тогтоол батлагдсан/. -СЯ-наас ЗГ-ын 2016 оны 198 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх сэргээгдэх эрчим хүчний судалгаа, шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийн жагсаалт"-д сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослон ажиллах	01.01- 12.10	95

				эрчим хүч хуримтлуурыг нэмж тусгахаар ирүүлсэн 3Г-ын тогтоолын төсөлтэй танилцан, 6 барааны ангиллын кодыг тодорхойлон 2024.10.15-ны өдрийн 01/4213 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. Энэ тогтоолын төсөл нь 3Г-ын 2024 оны 10-р сарын 30-ны өдрийн 150 дугаар тогтоолоор батлагдсан. -3Г-ын 2002 оны 219 тогтоолын 1 дүгээр хавсралтад батлагдсан “Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт”-д заасан барааны 6 ангиллын кодыг одоо мөрдөгдөж буй 10 кодтой харьцуулсан лавлагааг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2024.05.03-ны өдрийн 02-2.1/1780 тоот албан бичгээр хүргүүлэв. -3Г-ын 2023 оны 12-р сарын 07-ны өдөр батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд заасан гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлэгчийн талаар болон гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны жагсаалтыг тодорхой болгон ирүүлэх тухай 2024.05.10-ны өдрийн 02-2.1/1869 тоот албан бичгийг НЗДТГ-т хүргүүлсэн. -ХХААХҮЯ-аас боловсруулсан “Гаалийн татвараас чөлөөлөгдөх оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлох, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй түүхий эд, үндсэн болон туслах материалын жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд хавсаргасан 131 нэрийн барааны ангиллын кодыг БТКУС-ийн дагуу тодорхойлон, тогтоолын төсөлд санал оруулан, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/4978 тоот албан бичгээр Сангийн яам, ХХААХҮЯ-нд хүргүүлэв. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар хойшлуулах барааны ангиллын кодыг тодорхойлох ажил. ГТГТТХ-ийн 38.1.20, 38.1.21, 40.4 болон 40.5-т заасны дагуу, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан “Татвар төлөх хугацааг сунгуулах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэлээ: -Дээрх төслийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2024 оны 02 сарын 29 өдөр ГЕГ-ын ТОГ, БАҮХ, ХБГ хамтран Үйлдвэрлэл, технологийн парк болон Эрчим хүчний төслийг хэрэгжүүлж буй Цэнгазар ХХК, Цэцэнс майнинг энд энерги ХХК, Си Өү Эй Эл ХХК, Инфинити Спэйс ХХК зэрэг байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, санал солилцов. - Бүрдүүлэлтийн цахим төвтэй хамтран нийт 6 төслийн нийт 6725 барааны ангиллын кодыг тодорхойлон, холбогдох яам, байгууллагуудад хүргүүлсэн байна. Эдгээр төслүүд бүгд нийт 769,901,832.4 ам.долларын үнийн дүнтэй гурвалсан гэрээг байгуулан, амжилттай хэрэгжиж байна. Үүнд: - 3Г-ын 2023 оны 337 дугаар тогтоол, 3Г-ын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37-р тогтоолд заасан “импортлох техник, тоног төхөөрөмжийн иж бүрдлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх” ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт Дөрвөлжин шохойн чулууны ордыг түшиглэн баригдах Тайшир шохойн үйлдвэрийг барих Цэнгазар ХХК-ны ирүүлсэн 78 багц, 791 тоног төхөөрөмжийн ангиллын кодыг тодорхойлон 2024.03.20 өдрийн 01/1030 тоот албан бичгээр хүргүүлэв./БЦТ-ийн ГУБ Н.Оуюнтөгс, О.Бүжинлхам, Э.Мөнхцэцэг нар 506 барааны ангиллын кодыг, БАҮХ-ийн ГУБ Р.Хулан 285 барааны кодыг тодорхойлсон/. - Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор “Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт Бөөрөлжүүгийн нүүрсний уурхайг түшиглэн баригдаж буй 300 МВт-ын цахилгаан станц”-ын төслийн барилга, угсралтад зориулан импортоор		
--	--	--	--	--	--	--

оруулж ирэх тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилийн хугацаагаар сунгахаар шийдвэрлэсэн. Дээрх төсөлд зориулан импортлох нийт **21 багц, 1694** нэр төрлийн тоног төхөөрөмжийн ангиллын кодыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны ангиллын жагсаалт"-ын дагуу тодорхойлов. /БЦТ-ийн ГУБ Б.Батжаргал, Э.Одгариг, Э.Халиунаа нар 491 барааны кодыг тодорхойлсон, БАҮХ-ийн ГУБ Р.Хулан 1203 барааны кодыг тодорхойлсон/. 2024.05.29-ний өдрийн 01/2122 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Сангийн яамнаас 2024 оны 08-р сарын 02-ны өдрийн 04/6491 тоотгоор ирсэн гурвалсан гэрээний хавсралт жагсаалтын **1614** барааны ангиллын кодыг дахин хянаж, саналыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 02/3202 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. **Нийт 3308** /давхардсан тоогоор/

- Завхан аймгийн нутагт баригдах 30 МВТ-ын суурилагдсан хүчин чадалтай цахилгаан станцын барилга угсралтын ажилд зориулан импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, бараа материалд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх ажлын хүрээнд үндсэн гүйцэтгэгч **ХХК-ийн импортлох нийт 140** барааны барааны ангиллын кодыг тодорхойлж 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 01/2744 тоот албан бичгээр Сангийн яам, ЭХЯ, Тосон Энержи ХХК-д хүргүүлсэн. БЦТ-ийн ГУБ Б.Жаргал, М.Хэрлэнбаатар, Б.Туяа нартай хамтран ажилласан. Төсөл амжилттай хэрэгжиж байна.

-Засгийн газрын 2024 оны 08-р сарын 14-ний өдрийн 35 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд баригдах 50МВт-ын чадалтай дуолааны цахилгаан станцын төсөлд зориулан **ХХК-ийн импортлох нийт 140** барааны барааны ангиллын кодыг тодорхойлж ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх ажлын хүрээнд гурвалсан гэрээний хавсралтад орох нийт **121** нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлон 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 02-2/3467 тоот албан бичгээр Сангийн яам, ЭХЯ болон **ХХК-д** хүргүүлэв.

- Засгийн газрын 2024 оны 09-р сарын 18-ний өдрийн 85 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт баригдах "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн төсөлд зориулан **ХХК-ийн дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж ирэх барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжид ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хугацааг 4 жилийн хугацаагаар сунгах ажлын хүрээнд гурвалсан гэрээний хавсралтад орох нийт 1915** нэр төрлийн барааны ангиллын кодыг БЦТ-ийн ГУБ Ц.Баярмаа, Д.Тунгалаг, Г.Энхтуяа нартай хамтран тодорхойлон 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 01/4010 тоот албан бичгээр Сангийн яам болон **ХХК-д** хүргүүлэв.

- **ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх** **ХХК** нь татвараас чөлөөлөгдөн импортлох тоног төхөөрөмж, эд анги, бараа материал нийт **611** нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлуулах хүсэлт ирүүлснийг судлан жагсаалтын ширэм, хорголжны үйлдвэрийн нийт **286** тоног төхөөрөмж, бараа материалаас **107** барааны ангиллын кодыг тодорхойлон 159 барааны нэмэлт тайлбар, тодруулга авах асуултыг боловсруулан цахим хаягаар хүргүүлсэн. Мөн нүүрс, коксны үйлдвэрийн тоног төхөөрөмжийн талаар нэмэлт тайлбар, тодруулга авах асуултыг боловсруулан хүргүүлсний дагуу ирүүлсэн тайлбарыг судлан **57** барааны ангиллын кодыг тодорхойлох ажлыг хийсэн. **Нийт 450** барааны код тодорхойлсон.

10	Барааны ангилал	Хэрэгжилт, гүйцэтгэл-лээр	-	3. Нягтлан шалгах санд оруулсан мэдээлэлд судалгаа хийх, түүний мөрөөр арга хэмжээ зохион байгуулсан байна.	Тайлант хугацаанд CAIS дахь "Үнийн мэдээллийн сан" цэсний "Нягтлан шалгах үнийн жагсаалт"-д орсон бичлэгээс "БТКУС-ийн код буруу" 134 барааны ангиллын кодыг хянасан. CAIS-д 2024 оны 1-р, 2-р улирлын байдлаар бүрдүүлэлт хийгдсэн бичлэгүүдийг хянан, барааны ангиллын кодын алдааны талаар судалгаа гарган, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.05.02-ны өдөр, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний 3 удаагийн сургалтаар холбогдох алдааг анхааруулсан. Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем (CAIS)-д 2023, 2024 онд БТКУС-ийн жагсаалтын Зүйл 84.01 /цөмийн реактор/ ангиллын кодоор буруу бүрдүүлэлт хийгдэж байгаа тул ГЕГ-ын Хяналт, бүрдүүлэлтийн газарт зохих хязгаарлалтыг оруулах шаардлагатай тухай Дотоод зурвас хүргүүлсэн. Үүний дүнд, CAIS програмд Зүйл 84.01 ангиллын кодоод "хязгаарлалттай импорт" анхааруулга гаргадаг болгосноор мэдүүлгийн алдаа гарахаас сэргийлэх ажил болсон.	01.01-12.10	90
11	Барааны ангилал	Хэрэгжилт, гүйцэтгэл-лээр	90	4. Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулан шийдвэрийн санг баяжуулсан байна.	1. Тус хэлтсийн ажлын чиг үүргийн хүрээнд ДГБ-аас гаргасан бодлогын бичиг баримтыг орчуулах, хэрэгжүүлэх зорилгоор ДГБ-ын "WCO trade tools" дээр интернет орчинд барааны ангилал, гаалийн үнэлгээ, барааны гарал үүсэл сэдвээр ажиллах эрх /Full pack -1 year, online subscription/-ийг авах ажлыг зохион байгуулж, 1 жилийн хугацаатай ДГБ-ын гишүүн орны хөнгөлөлттэй үнээр буюу 350 еврогоор авах холбогдох санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлж, он лайн эрхийг авсан. Тус эрхийг авснаар ДГБ-ын УСХорооны шийдвэрийг цаг тухай бүр авах, мөн Монгол Улс БНСУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд ГЕГ-аас хэлэлцээрийн багт ажиллаж байгаа ажилтнууд ашиглах боломжтой болсон. 2. Уялдуулсан системийн хорооны шийдвэрээс 56 шийдвэрийг орчуулан, Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн УСХ-ны шийдвэрийн санд оруулан, ГУБ нарт тодорхой барааны ангиллын талаарх мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн.	01.01-12.10	90
12	Барааны ангилал	Хэрэгжилт, гүйцэтгэл-лээр	100	5. Харьяа гаалийн газар, хороодыг барааны ангилалтай холбоотой удирдамж чиглэлээр хангах, зөвлөгөө өгөх, асуудал хариуцсан ажилтнуудыг сургалтад хамруулах, чадавхижуулах ажлыг зохион байгуулсан байна.	Харьяа гаалийн газар, хороод болон ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад барааны ангиллын чиглэлээр 7 удаа чиглэл, зөвлөмжийг албан бичиг болон дотоод зурвасаар өгч хамтран ажилласан. Үүнд: - Бүрдүүлэлтийн цахим төвд ГЕГ-аас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нэг төрлийн барааг өөр өөр ангиллын кодоод хамааруулан ангилах, татварыг багаар төлөх боломжийг олгосон алдааг дахин гаргахгүй байх, ялангуяа Зүйл 90.18-д ангилан мэдүүлсэн барааны ангиллын кодыг нягтлан шалгах чиглэлийг 2024.03.12-ны өдрийн 02-2.1/047 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. - 2024 оны 1 дүгээр улиралд бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгүүдээс ялгавартай татвартай барааг бага татвартай бараагаар мэдүүлэх магадлал бүхий 6810.99.00, 7019.80.00, 9018.39.00, 9018.90.00 кодуудаар ангилж бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгүүдийг нягтлан шалгаж, БЦТ-ийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУАБ, ГУБ нарт 2024 оны 05-р сарын 02-ны өдөр зохион байгуулсан сургалтын үеэр алдаатай хийгдсэн мэдүүлгүүд болон цаашид анхаарах асуудлаар чиглэл, зөвлөмжийг өгсөн. Өгсөн чиглэл зөвлөмжийн дагуу "гааль зөвшөөрөв" төлвөөс буцаан 6 мэдүүлгийн 19 барааны ангиллын кодыг засварлаж, нийт 6,9 сая төгрөгийн татварыг нэмж төлүүлсэн. - Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад 2024 оны 04-р сарын 05, 25-ны өдрүүдэд нийт 112 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд барааны ангилал болон анхаарах асуудлын талаар сургалт хийсэн. - Тус хэлтсээс БЦТ-ийн ГУБ нарыг хамруулан зохион байгуулсан "Гаалийн үнэлгээний ахисан шатны сургалт"-д ДГБ-ын Уялдуулсан системийн хороо, хорооноос гаргасан ангиллын шийдвэрүүдийн талаарх танилцуулгыг бэлтгэн танилцуулсан.	01.01-12.10	95

					- Бүрдүүлэлтийн цахим төвийн барааны ангилал хариуцсан ГУАБ нарт барааны ангиллын кодын алдааны талаар SPARK-дотоод сүлжээгээр мэдэгдэн, засуулж ажилласан -3 удаа. - Дархан-Уул аймаг дахь ГГ-ын 2024.06.17-ны 02-247 тоот албан бичгээр "гичний үр" гэх барааны ангиллын кодыг тодорхойлуулах хүсэлтийг судлан, ГТХ-ийн 254.2-т заасны дагуу давтан магадлан шинжилгээ хийлгэхийг зөвлөв. - ГЕГ-н БАҮХ ЧХОУНБГГ-тай хамтран "Монгол улсад бүртгэлтэй импортын хүний эм, эмийн бүтээгдэхүүний БТКУС-ийн дагуу кодлосон жагсаалт, унификация, зөвлөмж" цахим жагсаалтыг боловсруулж, нийт МУ-д бүртгэлтэй 5142 эмийн барааны ангиллын кодыг хянаж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. Улмаар 2024.08.06-ны өдөр дээрх жагсаалтыг цахим лавлах хэлбэрээр https://online.fliphtml5.com/iggux/zust/, "Монголын гааль", "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан есны групп" зэрэгт байршуулан нийтийн хүртээл болгосон.		
13	Барааны ангилал	Хэрэгж илт, гүйцэтг э-лээр	-	6.Их өгөгдлийг ашиглан хиймэл оюун ухааны тусламжтайгаар барааны ангиллын код тодорхойлоход лавлагаа болгон ашиглах платформын туршилт хийх бодлогын даалгавар боловсруулсан байна.	Гадаад худалдаанд оролцогчид гаалийн мэдүүлгийг нөхөн бичихэд гарч буй хүндрэлийн нэг нь тухайн бараанд таарах зөв БТКУС-г олох асуудал байдаг учраас "Хиймэл оюу ухаанд суурилсан БТКУС код санал болгох систем"-г МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул хөгжүүлж эхэлсэн. Импорт, экспортын барааны нэр, марк модел, онцлог шинж гэсэн талбаруудыг авч өгөгдлийн бэлтгэн, цэвэрлэж ДГБ-н БАКУДА төслөөс санал болгосон Doc2Vec моделийг ашиглан машин сургалтаар моделийг сургасан. Doc2Vec бол баримт (document) эсвэл текстийн цогц мэдээллийг векторын хэлбэрт хувиргаж, машин сургалтанд ашиглахад тохиромжтой хэлбэрт оруулах зориулалттай байгалийн хэл боловсруулалтын (NLP) аргачлал юм. Машин сургалтаар мэдүүлгийн өгөгдлийн сангаас сүүлийн 3н жилийн датагаар машин сургалтын хийж ассигасу буюу моделийн магадлал 80-с дээш хувьтай гарч системийн эхний хувилбар бэлэн болсон. Үүнийг Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс зарим нэр төрлийн бараанд туршилт хийсэн. Платформыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болох ДГБ-ын BACUDA хөтөлбөрийн буй Их өгөгдлийг ашиглан хиймэл оюун ухааны тусламжтайгаар барааны ангиллын код тодорхойлоход лавлагаа болгон ашиглах платформ (AI Based HS Code recommendation system)-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг туслалцаа авч, хамтран ажиллах хүсэлтэй байгаа талаар ДГБ-д уламжлуулахаар ГХАХ-т 2024.04.19-ний өдрийн 02-2.1/80 тоот дотоод зурвасыг хүргүүлсэн. Мөн ГУБ Мөнхзулаас БАКУДА төслийн багтай байнга холбогдож, ажлын явц, хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, биелэлт зэргийг хүргүүлж ажиллан, зарим чиглэл зөвлөмжийг авч ажилласан байна. БАҮХ-ийн дарга Ч.Чимгэрэл нь БНСУ-д ажлын томилолтоор ажиллах хугацаандаа төслийн хариуцсан албаны хүмүүстэй ажлын уулзалт хийж, цаашид ажиллах чиглэлийг харилцан тохиролцсон болно.	01.01-12.10	83
Зорилт 3." Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх"							
1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгж илт, гүйцэтг э-лээр	100	ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны хуралдаанд оролцох, холбогдох шийдвэрийг орчуулсан байна.	1. ДГБ-ын Уялдуулсан системийн Хорооны 73 дугаар хуралдаанд БАҮХ-ийн БТКУС хариуцсан 2 ГУБ-ийн хамт 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс 15-ны өдрийг дуустал, 74 дүгээр хуралдаанд 9.16-27-ны хооронд он лайнаар оролцов. Тус хуралдаанд ДГБ-ын 161 гишүүн орны 63 гаалийн байгууллагын төлөөлөгчид биечлэн оролцож, бусад улсууд он лайнаар оролцлоо. Тус хуралдаанаар ажлын хэсгийн бэлтгэсэн 20 барааны ангилал, мөн цаашид судлах 19 бараа, шинээр танилцуулах 20 бараа, дахин нягтлах 5 бараа нийт 64 барааны ангиллын асуудлыг хэлэлцэж зарим барааны ангиллын шийдвэр гаргаж, БТКУС-ийн 2028 оны нэмэлт, өөрчлөлтөд оруулах зарим барааны ангиллын асуудлыг хэлэлцэв. БТКУС-ийн асуудлаар нэгдмэл байдлыг хангах, цаашдын стратегийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, гишүүн орнуудад танилцуулах зорилгоор	01.01-12.10	90

				стратегийн үнэлгээний судалгаа хийснийг танилцуулав. Мөн гаалийн лабораторийн гарын авлагыг шинэчлэх асуудлаар холбогдох танилцуулгууд хийгдэв. 2. ДГБ-ын Гаалийн үнэлгээний Техникийн хорооны 58 дугаар хуралдаанд 2024 оны 04.15-19-ний хооронд болж, БАҮХ-ийн ГУАБ, 2- ГУБ цахимаар оролцсон. 3. ДГБ-аас гаргасан 15 шийдвэрийг орчуулсан. 4. Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарын газраас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 24-ний өдрийн хооронд зохион байгуулсан "ДХБ-т Гаалийн үнэлгээний асуудлаар мэдэгдэл хүргүүлэх нь" сургалт Швейцар Улсын Женев хотноо зохион байгуулагдаж Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн ГУАБ Н.Цолмон оролцсон. Сургалтаар Гаалийн үнэлгээтэй холбоотой үндэсний хууль тогтоомжид "Шалгах хуудас"-аар мэдэгдэл гаргахад анхаарах асуудлууд, шаардлагуудын талаар танилцуулсан. 5. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр оролцов. ДХБ-ын гишүүн орнууд Гаалийн үнэлгээний асуудлаар нийт 28 гишүүн орны мэдэгдлийг үүний дотор Монгол Улсын хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа эсэх асуудлыг ДХБ-аас хянасан тухай мэдээллийг авч хэлэлцсэн. Гаалийн үнэлгээний Хорооны хуралдаанаас гаалийн үнэлгээтэй холбоотой асуудлуудыг зохицуулж буй Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа тухай Монгол Улсын мэдэгдлийг хүлээн авсан. ДХБ-ын гишүүн орнууд Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн 22 дугаар зүйлд заасны дагуу гаалийн үнэлгээний асуудлаарх хууль тогтоомжоо мэдэгдэхээс гадна тус хууль тогтоомжийн нийцлийг 15 асуулт бүхий "Шалгах хуудас"-аар гаргаж, ДХБ-д мэдэгдэх үүрэг хүлээдэг. Тус сургалтанд хамрагдсанааар МУ-ын "Шалгах хуудас" мэдэгдлийг төсөл байдлаар бэлтгэж, төслийг ДХБ болон ГХЯ-нд хүргүүлсэн. Олон улсын гэрээ хэлэлцээрт үндэсний хууль тогоомж нь нийцсэн байх нь ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, МУ-аас бусад улс оронтой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой гарч байгаа маргаантай болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.		
Зорилт 4. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"						
Нэгжийн эрсдлийг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн эрсдлийг таньж тогтоосон байна. Эрсдлийг бууруулах арга хэмжээ авсан байна.	Нэгжийн дотоод эрсдэл буюу хүний нөөцийн мэргэшсэн байдал ба ур чадвар, ажлын ачаалал ажиллах орчин, хууль тогтоомжийн хэрэгжилт болон бусад эрсдлүүдийг судлан, дараах эрсдлүүдийг тодорхойллоо. Үүнд: 1.Хүний нөөцийн эрсдэл: тус нэгжид хариуцсан чиглэлээрээ олон жил ажилласан, мэргэшсэн боловсон хүчин ажиллаж байгаа хэдий ч, 2024 он МУ-ын хэмжээнд хэрэгжиж буй үйлдвэр технологийн парк, эрчим хүч, дулааны цахилгаан станц зэрэг ажлын улмаас нэг хүнд ногдох ажлын ачаалал ихссэн. Иймд нэгжийн хүний нөөцийн эрсдлийг бууруулах, шилжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллав. - Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалаар БЦТ-ийн бүтэц, орон тоог баталсантай холбогдуулан 2024.03.13-ны өдрийн МЗХ-ийн ээлжит бус хуралдаанаар "БЦТ-ийн албан хаагчдын АТТ-д "Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх барааны ангиллын кодыг тодорхойлох" гэж оруулах асуудлыг хэлэлцүүлж, 03/02 тоот тэмдэглэлээр шийдвэрлүүлсэн. АТТ-ыг БЦТ-тэй хамтран боловсруулж, төслийг ЗУГ-		92

т хүргүүлсэн. БАҮХ-ээс БЦТ-ийн нийт 12 ГУБ-тай хамтран нийт 6 төсөл арга хэмжээний 6725 барааны кодыг тодорхойлох ажлыг зохион байгуулсан.

- ГЕГ-ын даргын түр тушаалаар гаалийн газар, хорооноос 3 ГУБ-ийг гаалийн үнийн бааз бүрдүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллуулсан.
- Хууль хяналтын байгууллагад татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй зөрчлийн улмаас Цагдаа, Тангуулын байгууллага болон АТГ шалгагдаж буй хэрэгт тус хэлтсээс шинжээчээр томилогдон ажилладаг. Тус нэгжийн хувьд чиглэл хариуцсан албан хаагчид нөлөөнд автах, хууль ёсны гаргасан шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлөх, ажлын ачаалал зэрэг эрсдэл байгаад судалгаа дүгнэлт хийн Гаалийн үнэлгээний ахисан түвшний сургалтын хөтөлбөрт шинжээчийн эрх үүргийн талаар тусган АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мэргэжилтэн хичээл заасан. Гаалийн үнэлгээний ахисан түвшний 24 цагийн сургалтын амжилттай зохион байгуулснаар тус сургалтад хамрагдсан нийт 15 албан хаагчид Эрүүгийн хэрэг хянана шийдвэрлэх тухай хуулийн 27.4-заасан шаардлагыг ханган шинжээчээр томилогдон ажиллах боломжийг бүрдүүлж ажиллаа.

2. Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн эрсдлийг ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаал аар баталсан "Гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам" – т заасан аргачлал буюу Квартелийн дүрмээр тооцон гаргасан.

Үүнд дараах эрсдэлт хүчин зүйлийг тооцсон болно:

1. Үнийн мэдээллийн сангийн эрсдэл
2. Гомдол, маргааны эрсдэл
3. Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний алдааны эрсдэл
4. Барааны ангиллын алдааны эрсдэл
 - ✓ Үнийн мэдээллийн сангийн эрсдлийн оноо – үр дүн дунд зэрэг буюу бага хэмжээний хүчин чармайлтаар залруулах боломжтой.
 - ✓ Гомдол маргааны эрсдлийн хувьд үр дагавар өндөр тул ихээхэн хүчин чармайлт гарган залруулах боломжтой.
 - ✓ ГБМ алдааны эрсдлийн хувьд үр дагавар өндөр, ихээхэн хүчин чармайлт гаргаж залруулах боломжтой.
 - ✓ Барааны ангиллын алдаану хувьд үр дагавар өндөр тул ихээхэн хүчин чармайлт гарган залруулах боломжтой.

Дээрх аргачлалаар 2024 оны 09 сарын 30-ны байдлаар дүн шинжилгээ хийхэд БАҮХ-ийн дээрх эрсдэл 48.5 %, 11 сарын 30-ны байдлаар хийсэн дүн шинжилгээгээр 34.24 % болж буурсан байна. Тухайлбал:

ҮМС-ийн эрсдэл 2024 оны 09.30-ны өдрийн байдлаар 34.56 % байсан бол 11.30-ны өдрийн байдлаар 23.2 % болж, гомдол маргааны хувьд 0.13 % байснаа 0.12 % болж тус тус буурсан байна. Алдааны хувьд ГБМ-ний гаалийн мэдүүлгийн алдааны эрсдэл 09 сарын 30-ны байдлаар 10.03% байсан бол 7.29 % болж, барааны ангиллын алдааны эрсдэл 3.78 % байсан бол 3.63 % болж тус тус буурчээ. Энэ оны 9 сарын 30-нд нэгжийн эрсдэл 48.5% байсан бол 11 сарын 30-ны байдлаар 34.24% хувь болж буурсан нь Үнийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, цахимжуулах боломжийг судлах зорилгоор ГЕГ-ын даргын 2024.07.02-ны Б/513 дугаартай тушаалаар 3 албан хаагчийг тус нэгжид түр тушаалаар ажиллуулж байгаатай холбоотой болно.

2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	Бүрдүүлэлтийн цахим төв байгуулагдсант ай холбогдуулан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.	1. Бүрдүүлэлтийн цахим төв байгуулж гаалийн бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлснээр гаалийн зуучлагчид тавих хяналтыг сайжруулах зорилгоор ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих тухай журам"-ыг шинэчлэн боловсруулсан. Судалсан материалууд: - ДГБ-ын "Гаалийн зуучлагч" гарын авлага - ДГБ-ын "Гаалийн зуучлагчийн асуудлаарх судалгааны тайлан" - ОХУ-ын Гаалийн тухай хууль, Гаалийн зуучлагчийн үйлчлүүлэгчтэй байгуулах гэрээ - Канад Улсын гаалийн зуучлагчид лиценз олгох журам - Энэтхэгийн гаалийн зуучлагчид лиценз олгох журам - БНХАУ-ын гаалийн зуучлагч бүртгэх журам Төслийг ГЕГ-ын удирдлагуудад танилцуулж, гаалийн байгууллагын цахим хаягт санал авахаар байршуулсан. ЗББНДГ, гаалийн харьяа газар, хороод, Монголын зуучлагчдын холбооноос албан бичгээр санал авч холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгасан. ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, гаалийн газар, хороо, Монголын гаалийн зуучлагчийн мэргэшсэн холбоо ТББ-аас нийт 188 санал ирүүлсэн. Үүний 78 саналыг журмын төсөлд тусгасан нь 41,4 %-ийг эзэлж байна. Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбооноос 27 санал ирүүлсэн бөгөөд 11 санал тусгасан нь 40,7 % эзэлж байна. Мөн Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төслийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх газар, гаалийн газар хороод буюу ЗУГ, ХБГ, ТОГ, ХШҮДАГ, ЗТГ, ХХ, БАҮХ, БЦТ, УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-аас 24 албан хаагч, Монголын гаалийн зуучлагчийн мэргэшсэн холбоо, гаалийн зуучлагч байгууллагыг төлөөлж 27 ААН-ийн 28 албан тушаалтан нийт 52 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн явцад хэлэлцүүлэгт оролцогчдоос 9 асуудлыг хөндөж асуулт тавьсан. Санал асуулгын хуудсаар 20, нийт давхардсан тоогоор 29 асуудлыг хөндөж санал ирүүлснийг дахин нягталж эцсийн байдлаар журмын төслийг боловсруулсан. Хуулийн хэлтэст 2-2.1/102 тоот дотоод зурвасаар төслийг хянуулан хариуг авсан. Мөн Сангийн яаманд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/1841 дугаартай албан бичгээр журмын төслийг хянуулахаар хүргүүлсэн. Журмын төслийг МЗХ-аар 2024.12.13-ны өдөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	01.01-12.10	93
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгж илт, хувиар	100%	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сангийн сайдаас өгсөн үүрэг даалгаврын хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой заалтын хэрэгжилтийг	- Сангийн яаманд хүргүүлдэг тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны байдлаар өөрийн нэгжийн чиг үүрэгт хамаарах 4 ажлын биелэлтийг гаргаж, 2024.02.29-ний 02-2.1/040 дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хүргүүлсэн. - Гаалийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус нэгжийн чиг үүрэгт хамаарах ажлын гүйцэтгэлийг нэгтгэн ЗУГ-т 2024.01.04-ний 02-2.1/2 дотоод зурвасаар хүргүүлсэн. - ГТГТТХ-ийн 38.1.20, 38.1.21, 40.4 болон 40.5-т заасны дагуу, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгуулах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бүрдүүлэлтийн цахим төвтэй хамтран нийт 6 төслийн нийт 6725 барааны ангиллын кодыг тодорхойлон, холбогдох яам, байгууллагуудад хүргүүлсэн байна. Эдгээр төслүүд бүгд	01.01-12.10	90

				ханган ажилласан байна.	нийт 769,901,832.4 ам.долларын үнийн дүнтэй гурвалсан гэрээг байгуулан, амжилттай хэрэгжиж байна. - Мөн, Засгийн газрын 2024 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилын жагсаалт, Засгийн газрын 2016 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан гааль, нөөт -аас чөлөөлөгдөх барааны жагсаалтад БТКУС-ийн дагуу кодолж санал хүгүүлэн одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байна.		
4	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажилласан байна.	- ХШҮДАГ-т 2024.02.07-ны 02-2.1/23 дотоод зурвасаар "ГЕГ-ын Барааны ангилал, гаалийн үнэлгээний асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааны шалгуур, үзүүлэлт", тушаалын 2.9 дүгээр хавсралт "ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын барааны ангилал, үнэ, үнэлгээний үйл ажиллагааны шалгуур, үзүүлэлт"-д тус тус санал өгсөн. - Тус нэгжийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан тайлан мэдээ, үнийн мэдээллийн сан, үнийн судалгаа, гомдол, маргаан шийдвэрлэлтийн танилцуулга, хийсэн гаалийн үнийн төрөлжсөн судалгаануудын файл, нэгжийн чиг үүрэгтэй холбоотой хууль, журмуудыг файлаар тус тус хүргүүлж, ХШҮДАГ-ын ГУАБ-тай уулзаж, тайлбар мэдээлэл өгч ажилласан. - ЗДАП-аар ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн 6, СТ-өөс 2, Ёс зүйн дэд хорооны хуралдаанаас өгсөн 1 үүрэг даалгавар нийт 9 үүрэг даалгавар болон ХШҮДАГ-аас 2023, 2024 онуудад өгсөн 19 зөвлөмжийн биелэлтийг гаргаж, тухай бүр оруулсан. - ТОГ-ын даргаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд татварын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2024 оны эхний 3 сар, 4 сар, 5 сар, 8, 9, 10 сарын байдлаар гаалийн үнэ буурсан барааны судалгаа 6 удаа, тарифын ялгавартай барааны судалгаа зэргийг гаргаж, газар, хороодтой хийсэн онлайн хуралд барааны ангилал, үнэлгээний чиглэлээр анхааруулга, санамж бэлтгэн оролцсон. - 2024.03.13-ны өдрийн МЗ-ийн хуралдаанаар "БЦТ-ийн албан хаагчдын АТТ-д "Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх барааны кодыг тодорхойлох" асуудлыг тусгаж шийдвэрлүүлэв. БЦТ-тэй хамтран нийт 6 төслийн 6675 тоног төхөөрөмжийг БТКУС-ийн дагуу кодлон төслийн үйл ажиллагааг эхлүүлсэн. - МЗ-ийн хурлаар "Автомашинь системээс шалгах заавар"-ын төслийг хэлэлцүүлж, ГЕГ-ын даргын А/533 тушаалыг батлуулж, холбогдох програмыг амжилттай нэвтрүүлж ажиллав.	01.01-12.	93
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Ажлын цагийн хоцролт, тасалдалгүй ажилласан байна.	1. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу газрын бүх албан хаагч нар цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай үед гадуур ажиллах, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд CERP-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. Нийт албан хаагчид ажлын хоцролт тасалдалгүй, ажлын цаг ашиглалт сайн ажиллав. 2024 онд нийт 151.8 цаг буюу 19 өдөр илүү цагаар ажилласан. Дараах ажлуудыг хийж, илүү цагаар ажилласан байна: - ДГБ-ын УСХ-ны 73-р хуралдаанд 2024.03.06-15-нд, 74-р хуралдаанд 9.16-27-ны өдөр 3 албан хаагч 16.30-20.00, 22.00-01.00 цагуудад онлайн хэлбэрээр, мөн ДГБ-ын Гаалийн үнэлгээний Техникийн хорооны хуралдаанд 2024.05.06-10-ны өдрүүдэд 16.30-24.00 цагуудад 2 ГУБ онлайнаар оролцсон. - ГЕГ-ын даргын А/341 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд бусад орны	01.01-12.10	100

					хууль тогтоомж, журам болон ДГБ-ын судалгаа, тайлан зэрэг материалуудыг судалж, шаардлагатай тохиолдолд зарим орчуулгуудыг хийсэн. 4. "Санчир ундрах" ХХК-ний нэхэмжлэхтэй Захиргааны хэргийн 4 шүүх хуралдааны холбогдох материал, тайлбар бэлтгэж ажиллав. 6. ЗГ-ын 337 дугаар тогтоолын дагуу татвар хойшлуулах, чөлөөлөх 6 томоохон төслийн 6725 тоног төхөөрөмжийн жагсаалтыг яаралтай горимоор кодлох ажлыг хянаж гүйцэтгэсэн.		
6	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Цаг үеийн шинжтэй арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна.	1. ХШУДАГ-аас ГЕГ-ын даргын батлагдсан удирдамжийн дагуу БАҮХ-ийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тус хэлтсийн дараах холбогдох материалууд, тайлан, тайлбарыг гаргаж өгсөн. - ГБГ-ын 2022 оны ажлын тайлан, БАҮХ-ийн 2023 оны ажлын тайлан - ГБГ, БАҮХ-ийн үндсэн мөрдөж байгаа эрхийн актууд, МЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн асуудлууд, шийдвэрүүд - БАҮХ-ийн бүтэц, орон тоо, ажлын ачаалал, танилцуулга, - ГБГ, БАҮХ-ийн ГУБ нарын ажил үүргийн хуваарь - Ажлын хэсэгт ажилласан байдал - Гаалийн бүрдүүлэлт, барааны ангилал, үнэлгээ, зуучлагчийн чиглэлээр МТГ-т өгсөн програмын саналууд, шийдвэрлэгдсэн байдал - Гаалийн үнэлгээ, барааны ангиллын чиглэлээр шийдвэрлэсэн гомдол, маргаан, үр дүн, хэрэгжүүлсэн ажлууд - Гаалийн үнэлгээ, барааны ангиллын чиглэлээр хийсэн судалгаа, хэрэгжилт, бусад газар, хэлтсүүдтэй хамтран ажилласан байдал - Экспортын уул уурхайн бус бараатай холбоотой гомдол, шийдвэрлэлт - Гаалийн бүрдүүлэлтийн чиглэлээр татгалзсан, хүчингүй төлвийн мэдүүлгүүдэд тавьсан хяналт, хэрэгжүүлсэн ажлууд, гаргасан санал - Гаалийн бүрдүүлэлтийн чиглэлийн ажил хүлээлцсэн байдал, протокол - ГБГ, БАҮХ-ийн 2022, 2023 оны 7 хоног тутмын тайлан ХШУДАГ-аас ирүүлсэн холбогдох зөвлөмжийн хүрээнд ЗДАП-д хэрэгжилтийг тайлагнаж, хүргүүлсэн. 2. ОУВС-гийн 2021-2024 онд гаалийн байгууллагад хэрэгжүүлсэн "Гаалийн байгууллагын чадавхыг хөгжүүлэх төсөл"-ийн үр дүнг хэлэлцэх, ирэх 4 жилд гаалийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр харилцан санал солилцох асуудлаар тус бүс нутгийн гаалийн асуудал хариуцсан төслийн багтай хийх уулзалтанд 2024 оны 04 сарын 04-ний өдөр оролцож, экспортын гаалийн бүрдүүлэлт, гаалийн үнэлгээний чиглэлээр хийгдэж байгаа ажлуудыг танилцуулсан. 3. ТОГ-аас татварын орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр газар, хороодын дарга нартай хуралдсан 2 удаагийн онлайн хуралд оролцож, гаалийн үнэлгээ, барааны ангилал, зуучлагчийн асуудлаар чиглэл өгсөн. 4. ДХБ-аас 2024 оны 05.22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан "ДХБ-д гаалийн үнэлгээний асуудлаар мэдэгдэл хүргүүлэх нь" сэдэвт Швейцар Улсын Женев хотноо зохион байгуулагдсан сургалтад оролцсоноор ДХБ-т Гаалийн үнэлгээний хэлэлцээрт Монгол Улсын хүлээсэн үүргийн дагуу "Мэдэгдэл 1", "Мэдэгдэл 2"-ийг боловсруулан англи хэл дээр бэлтгэн хүргүүлсэн.	01.01-12.10	95

					5. Экспортонд гаргаж байгаа эрдэс бүтээгдэхүүний АМНАТ тооцох жишиг үнэ тогтоох Сангийн яам, УУХҮ-ийн сайдын хамтарсан ажлын хэсэгт орж ажиллан, сар бүр нийтэд олон улсын зах зээлийн үнийн мэдээллийг зарласнаар экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний гаалийн үнийг хэлцлийн бус аргаар тодорхойлоход ашиглаж байна. 2024 онд нийт экспортын уул уурхайн гаалийн бүрдүүлэлтийн 10 хувийг энэхүү эх сурвалжийн дагуу гаалийн үнийг тодорхойлсон. 6. Монгол Улс -БНСУ-ийн ЭЗТХ-ийн 2 удаагийн хэлэлцээнд "Барааны бүлэг", "Гарал үүсэл" -ийн бүлгүүдэд оролцон 3 дахь раундад амжилттай ажилласан. 7. АТГ-аас зохион байгуулсан "Санхүү, татвар, гаалийн байгууллагын цахимжилтыг шийдвэрлэх арга зам" хэлэлцүүлэгт оролцсон. 8. БАҮХ-ээс "Гаалийн үнэлгээний ахисан түвшний сургалт"-ыг зохион байгуулж, БЦТ-ийн ГУБ нарт АТГ-аас авилгаас ангид байх чиглэлээр сургалт авсан. 9. ГЕГ-ын батлагдсан төлөвлөгөөний ГЕГ, АТГ, ПЕГ-аас зохион байгуулсан авилгаас ангид байх сургалт, мэдээллийн цагт хамрагдсан.		
7	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлтсийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээний биелэлтийг ханган ажилласан байна.	1. ХАСХОМ-ээ шинэчлэн хуулийн хугацаанд хянуулан, цахимаар илгээсэн. 2. "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулж, журмын төслийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх газар, гаалийн газар хороод буюу ЗУГ, ХБГ, ТОГ, ХШУДАГ, ЗТГ, ХХ, БАҮХ, БЦТ, УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-аас 24 албан хаагч, Монголын гаалийн зуучлагчийн мэргэшсэн холбоо, гаалийн зуучлагч байгууллагыг төлөөлж 27 ААН-ийн 28 албан тушаалтан нийт 52 хүн оролцлоо. 3. "Монголын гааль" цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулж ажиллалаа: - Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гаалийн байгууллагад бараагаа үнэн зөв мэдүүлэх, барааг урьдчилан мэдүүлэх, барааны ангиллыг урьдчилан тодорхойлох асуудлаар видеог ХМА-тай хамтран хийж, нийтийн хүртээл болгосон. - ДХБ-аас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 24-ний өдрийн хооронд Швейцарын Женев хотноо зохион байгуулсан сургалт болон ДХБ-ын Гаалийн үнэлгээний хорооны хуралдаанд оролцсон талаарх мэдээлэл, ДХБ-т Гаалийн үнэлгээний асуудлаар мэдэгдэл хүргүүлэхийн ач холбогдлын талаар мэдээлэл бэлтгэж, олон нийтэд танилцуулсан. - "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан талаарх мэдээллийг байршуулсан.	01.01-12.10	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт.							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь

1	ДГБ болон ДХБ-аас боловсруулан гаргасан бодлогын бичиг баримтыг судлах, ДГБ-аас зохион байгуулах сургалтад хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	100	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	1. ДГБ-ын Уялдуулсан системийн Хорооны 73, 74 дугаар хуралдаанд БАҮХ-ийн БТКУС хариуцсан 2 ГУБ-ийн хамт 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс 15-ны өдрийг дуустал, 09.13-27-ны хооронд он лайнаар оролцов. Тус хуралдаанд ДГБ-ын 161 гишүүн орны 63 гаалийн байгууллагын төлөөлөгчид биечлэн оролцож, бусад улсууд он лайнаар оролцлоо. Тус хуралдаанаар ажлын хэсгийн бэлтгэсэн 20 барааны ангилал, мөн цаашид судлах 19 бараа, шинээр танилцуулах 20 бараа, дахин нягтлах 5 бараа нийт 64 барааны ангиллын асуудлыг хэлэлцэж зарим барааны ангиллын шийдвэр гаргаж, БТКУС-ийн 2028 оны нэмэлт, өөрчлөлтөд оруулах зарим барааны ангиллын асуудлыг хэлэлцэв. Ингэснээр өөрийн мэдлэг чадвараа дээшлүүллээ. 2. Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарын газраас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 24-ний өдрийн хооронд зохион байгуулсан "ДХБ-т Гаалийн үнэлгээний асуудлаар мэдэгдэл хүргүүлэх нь" сургалт Швейцар Улсын Женев хотноо зохион байгуулагдаж Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн ГУАБ Н.Цолмон оролцсон. Сургалтаар Гаалийн үнэлгээтэй холбоотой үндэсний хууль тогтоомжид "Шалгах хуудас"-аар мэдэгдэл гаргахад анхаарах асуудлууд, шаардлагуудын талаар судалсан. 3. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр оролцов. ДХБ-ын гишүүн орнууд Гаалийн үнэлгээний асуудлаар нийт 28 гишүүн орны мэдэгдлийг үүний дотор Монгол Улсын хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа эсэх асуудлыг ДХБ-аас хянасан тухай мэдээллийг авч хэлэлцсэн. Гаалийн үнэлгээний Хорооны хуралдаанаас гаалийн үнэлгээтэй холбоотой асуудлуудыг зохицуулж буй Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа тухай Монгол Улсын мэдэгдлийг хүлээн авсан. ДХБ-ын гишүүн орнууд Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн 22 дугаар зүйлд заасны дагуу гаалийн үнэлгээний асуудлаарх хууль тогтоомжоо мэдэгдэхээс гадна тус хууль тогтоомжийн нийцлийг 15 асуулт бүхий "Шалгах хуудас"-аар гаргаж, ДХБ-д мэдэгдэх үүрэг хүлээдэг. Тус сургалтанд хамрагдсанаар МУ-ын "Шалгах хуудас" мэдэгдлийг боловсруулан бэлтгэж, ГХЯ-нд хүргүүлсэн. 4. БНХАУ-ын гаалийн байгууллагаас 2024.10.23-11.05-ны хооронд Шанхай хотын гаалийн их сургуульд зохион байгуулсан "БНХАУ-д экспортолж буй бүтээгдэхүүний дүрэм, журам, хяналт шалгалт, хорио цээрийн талаар" сэдэвт сургалтанд ГЕГ-ын БАҮХ-ийн ГУАБ Н.Цолмон оролцлоо. Сургалтаар БНХАУ-ын импорт, экспортын бараа бүтээгдэхүүний сүүлийн үеийн нөхцөл байдал, импортын хүнсний аюулгүй байдлын тогтолцоо, түүнд тавих гаалийн хяналт шалгалт, хорио цээрийн асуудал, холбогдох гаалийн болон бусад хууль тогтоомжийн талаар мэдээлэл авч, зарим ухаалаг гаалийн боомт /Жянсу муж/, гаалийн лабораторитой танилцсан. Ажлын тайланг БАҮХ-ийн хамт олонд болон МУ-ын гаалийн байгууллагад хэрэгжүүлэх ажлын саналыг бэлтгэж удирдлагад танилцуулсан.	01.01-12.10	93
---	---	--	-----	---	---	-------------	----

2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100	Бие дааж уншиж судалсан байна.	Мэдээллийн цагтаа тухай бүр оролцсон. Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилын жагсаалттай танилцаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг хойшлуулахтай холбоотой ГТГТХ-ийн 38 дугаар зүйл, 40 дүгээр зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлт, ЗГ-ын 2023 оны 337 дугаар тогтоол зэрэгтэй танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	01.01-12.10	92
---	--	-------------------------	-----	--------------------------------	--	-------------	----

ТАЙЛАН
ГАРГАСАН:

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

 /Н.ЦОЛМОН /

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ НЭРГҮЙН ЦОЛМОНГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Барааны ангилал, үнэлгээний хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах					
1.	Гаалийн зуучлагч	55.4	9	64.4	
Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх					
1.	Гаалийн үнэ, үнэлгээ	55.1	9	64.1	
2.	Барааны ангилал	63.1	9	63.1	
3.	Ангилал, үнэ, үнэлгээтэй холбоотой асуудлаар маргаан, гомдлын шийдвэрлэлт, хяналт тавьсан байдал	53.0	10	63.0	
Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	63.0	10	63.0	
Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Нэгжийн эрсдлийг хэрэгжүүлсэн байдал	54.4	10	64.4	
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	54.1	10	64.1	
3.	Үүрэг даалгаврын биелэлт	55.1	10	65.1	
4.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	68.2	10	68.2	
Дундаж оноо:				64.97	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	ДГБ болон ДХБ-аас боловсруулан гаргасан бодлогын бичиг баримтыг судлах, ДГБ-аас зохион байгуулах сургалтад хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэх	93%	13.95	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	92%	13.8	
Дундаж оноо:			14.1	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	
Дундаж оноо:		7	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 8		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	64.97
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.1
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8

5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = 94.07 (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/Ч.Чимгэрэл/

2024-12-10

(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/Н.Цолмон/

2024-12-10

(огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/Г.Энхтайван/

2024-12-10

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/Ө.Тэгшээ/


2024.12.10

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Дарга

(албан тушаал)



.....

(гарын үсэг)

/Р.Отгонжаргал/

(огноо)